

*Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2009 онд
нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний
дагуу хийсэн байгаль орчны аудитын тайлан*



Ойн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт

**Хууль тогтоомжийн хэрэгжилт,
зохион байгуулсан ажлын бодит
үр дүн хангалтгүй байна**

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт 5
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 6
ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар	Бүлэг 1
<i>Захирал: Д.Ганбилэг</i>	Ойн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авсан зохион байгуулалтын арга хэмжээний үр дүн хангалтгүй байна
<i>Аудитын менежер: Х.Баярмаа</i>	Ажлын хэсэг байгуулж төлөвлөгөө гаргасан боловч зохион байгуулсан ажил, арга хэмжээнийхээ биелэлтийн явцыг дүгнээгүй байна 8
<i>Ахлах аудитор: Г.Цэдэнбалжир</i>	Хууль хэрэгжүүлэх талаар хурал, зөвлөгөөнөөр авч хэлэлцсэн боловч ажлын үр дүн харагдахгүй байна 9
<i>Шинжээч: Ц.Эрдэнэчулуун</i>	Зарим аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нар бүрэн эрхээ хэрэгжүүлэхгүй байна 9
<i>Л.Эрдэнэчулуун</i>	Хууль хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээний биелэлтийг дүгнэж, эрчимжүүлэх ажил хангалтгүй байна 10
2009 оны 11 дүгээр сар	Бүлэг 2
<i>Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.</i>	Хуулийг иргэдэд сурталчлах ажлын бодит үр дүн хангалтгүй байна
www.mnao.pmis.gov.mn	Ойн тухай шинэчлэгдсэн хууль тогтоомжийг сурталчлах ажил хийгдэж байгаа боловч үр дүн харагдахгүй байна 10
<i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263533 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>	Бүлэг 3
ХАЯГ:	Бүтэц , зохион байгуулалт хийхэд хугацаа алдсан байна
<i>Үндэсний аудитын газар 210642 Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс</i>	Ойн газар 2009 оноос үйл ажиллагаагаа эхэлжээ 12
	Аймаг, нийслэлийн БОА-ны бүтцэд ойн асуудал эрхэлсэн нэгж хуулийн дагуу зохион байгуулагдаагүй байна 13
	Зарим дүүргийн ойн салбар нэгжийн бүтэц, зохион байгуулалт хуулийн дагуу хийгдээгүй байна 13
	Ойн сангийн тодорхой хэсгийг нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх ажлыг хангалтгүй зохион байгуулж байна 14

Бүлэг 4	Бүлэг 7
Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагуудаас гаргах журам, заавар бүрэн гараагүй байна	Ойн нөөц төлөв байдлыг шинэчлэн тогтоосон байдал
Хуулийн дагуу гаргах 3 журам, зааврыг боловсруулаагүй байна 17	Ойн газраас 2009 оны 5 дугаар сарын 12-ны байдлаар улсын ойн сангийн талаарх мэдээллийг шинэчлэн тогтоосон ч зарим тоон үзүүлэлтийн өөрчлөлт үнэн зөв илэрхийлэгдээгүй байна 34
Ойн менежментийн улсын ерөнхий төлөвлөгөө хийгдээгүй, аймаг, нийслэлийн төлөвлөгөө бүрэн боловсруулагдаж дуусаагүй байна 18	
Бүлэг 5	
Хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн байдал	Аудитын дүгнэлт 37
Ой хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх зориулалтаар олгох хөрөнгийн төлөвлөлт ажлын гүйцэтгэл, үр дүнтэйгээ уялдахгүй байна 20	Холбогдох байгууллагын санал:
Ой зохион байгуулалтын санхүүжилтийг бодитой төлөвлөөгүй байна 23	Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн санал 38
Нөхөрлөлийн гэрээгээр эзэмших ойн санд хийх ой зохион байгуулалтын хөрөнгийг төсөвт тусгаагүй байна 24	Ойн газраас ирүүлсэн санал 39
Үнэт цаасны төлөвлөлт бодитой хийгдэхгүй, бүртгэл тооцоо хангалтгүй, хүчингүй болгосон үнэт цаасны тооцоог бүрэн хийгээгүй байна 25	Зөвлөмж 40
Ойн нөөц болон дагалт нөөц ашиглах төлбөр хураамжийг бүрэн тооцохгүй, орлогыг зориулалт бусаар зарцуулж байна 27	<u>ХАВСРАЛТУУД:</u>
Хуулийн дагуу ойн санг гэрээгээр эзэмшүүлэх ажил хийгдэхгүй байгаагаас хууль бусаар мод бэлтгэх ажиллагааг зогсоож чадахгүй байна 29	1. Аудитад хамрагдсан ойн нөхөрлөлийн судалгаа 41
Улсын хэмжээнд модны үрийн нөөц үндсэндээ алга байна 29	2. Ойн санг гэрээгээр эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын судалгаа 48
Ойн түймрийн шалтгаан нөхцөлийг үнэн зөв тогтоох, эзэн холбогдогчид хариуцлага хүлээлгэх ажил хангалтгүй байна 30	3. Ойн тухай хуулийн хэрэгжилтийн талаар авсан санал асуулга 1 49
Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажилд тавих хяналт сул, үр нөлөө хангалтгүй, тэмцэж буй арга оновчтой бус байна 31	4. Ойн тухай хуулийн хэрэгжилтийн талаар авсан санал асуулга 2 50
	5. БОАЖЯ-ны Байгаль хамгаалагчдаас авсан асуулгын нэгтгэл 51
	6. Ойн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитаар илрүүлсэн төлбөр, зөрчлийн жагсаалт 53
Бүлэг 6	
Боловсон хүчин хүрэлцээгүй байна	
БОА, ойн салбар нэгжүүд мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдаагүй байна 33	
БОАЖЯ-нд ойн мэргэжлийн боловсон хүчний хангалт, цаашдын төлөв байдлын талаар судалгаа алга байна 33	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	<i>Аж ахуйн нэгж, байгууллага</i>
БОАЖС	<i>Байгаль орчин, аялал жуулчлалын сайд</i>
БОАЖЯ	<i>Байгаль орчин, аялал жуулчлалын яам</i>
БОАЭТЗТБ	<i>Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага</i>
БОЯ	<i>Байгаль орчны яам</i>
БОС	<i>Байгаль орчны сайд</i>
БСУТА	<i>Байгалийн сэргэн ургалтад туслах ажил</i>
ГТХАН	<i>Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэг</i>
ДЦГ	<i>Дархан цаазат газар</i>
ЗДТГ	<i>Засаг даргын Тамгын газар</i>
ИТХ	<i>иргэдийн Төлөөлөгчдийн Хурал</i>
МҮОНРТ	<i>Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз</i>
ОУХСТ	<i>Ой, усны хайгуул судалгааны төв</i>
ТХГ	<i>Тусгай хамгаалалттай газар</i>
ТХСТГ	<i>Тогтвортой хөгжил, стратегийн төлөвлөлтийн газар</i>
ТХГХЗ	<i>Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа</i>
ОХЭГ	<i>Ойн хэрэг эрхлэх газар</i>

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2009 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийв.

Аудитын зорилт

Ойн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажил, арга хэмжээ, түүний үр дүнг үнэлж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, цаашид авах арга хэмжээг эрчимжүүлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Ойн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажил, арга хэмжээ, түүний үр дүн;
- Ойн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажил удаашралтай байгаа шалтгаан;
- Ой зохион байгуулалт, түүний санхүүжилт, зарцуулалт, ой ашиглахтай холбоотой үнэт цаасны бүртгэл, түүнд тавих хяналт үр нөлөөтэй эсэх.

Хамарсан хүрээ

Аудитад Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, нийслэл, дүүргийн болон ойн бүс бүхий Архангай, Булган, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Хэнтий аймаг дахь Байгаль орчны албад, зарим сумдын ойн анги болон ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын 2008-2009 оны үйл ажиллагааг хамруулсан болно.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитын дараахь арга зүйг ашиглав. Үүнд:

- Аудитад хамрагдсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа, тодруулга авах, судлах;
- Цуглуулсан мэдээ судалгаанд дүн шинжилгээ, харьцуулалт хийх;
- Ой зохион байгуулалтын арга хэмжээний гүйцэтгэгч сонгосон ажиллагааны талаархи материалыг түүвэрлэн авч, судлах, тодруулга авах;
- Захиалагчийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний гүйцэтгэлийг түүвэрлэн авч бодит байдалтай нь тулган баталгаажуулах, тодруулах;

- Ойн салбарын мэргэжлийн болон төрийн бус байгууллагын холбогдох мэргэжилтэнтэй ярилцлага хийж, холбогдох мэдээ, судалгаа гаргуулах;
- Сэлэнгэ аймгийн төр, захиргааны байгууллага болон БОАЖГ, зарим сум, багийн ойн нэгжид хуулийн хэрэгжилтийн байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, гүйцэтгэлтэй танилцах, тулган баталгаажуулалт, зураг авалт хийх;
- Ой зохион байгуулалт, зарим төвлөрсөн арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлийн санхүүгийн нотлох баримт материалд түүвэрчилсэн шалгалт хийх;
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Ойн газрын 2008-2009 оны хууль хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан заавар, журмын боловсруулалт, түүний хэрэгжилтийн байдал, ажлын тайлагнал, ойн салбарын мэдээ судалгааг авч, судлах;

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитыг ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар, ойн сан бүхий зарим аймаг, нийслэлийн аудитын газрын аудитор, шинжээчид гүйцэтгэв.

Ойн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт

Оршил

Ойн тухай хуулийг 2007 оны 5 дугаар сарын 17-ны өдөр шинэчлэн баталсан бөгөөд гол зорилт нь ойг хамгаалах, эзэмших, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах, ойг хамгаалахад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, төв орон нутагт төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллагын бүтцийг бий болгох, шинжлэх ухаан, технологийн үндэслэлтэй менежментийн төлөвлөгөөнд суурилан тогтвортой бодлого явуулах, ойн бүсчлэлийг шинэчлэн боловсруулах, ашиглалтын бүсийн ойг нэмэгдүүлэх, ойг эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэгдсэн болно.



Бүлэг 1. Ойн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээний бодит үр дүн хангалтгүй байна

Ажлын хэсэг байгуулж төлөвлөгөө гаргасан боловч зохион байгуулсан ажил, арга хэмжээнийхээ биелэлтийг дүгнээгүй байна

1.1 БОС-ын 2007 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 264 дүгээр тушаалаар хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хуульд тусгагдсан журам, заавар боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилон, боловсруулах 16 журам, зааврын жагсаалтыг баталжээ.

1.2 Ажлын хэсэг 2007 онд нэг ч журам заавар батлуулж чадаагүй, харин 2008 онд 2 журам батлуулсан байна.

1.3 Аудит хийх тухай шийдвэр гарсны дараа Ойн газрын даргын 2009 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 24 дүгээр тушаалаар хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор ажлын хэсэг байгуулж, хуульд тусгагдсан 10, хуулийн заалтад ороогүй боловч зайлшгүй гаргах шаардлагатай 6 журам, шинээр боловсруулж баталгаажуулах 5 заавар, журмын жагсаалтыг баталж, ажиллаж эхэлжээ.

1.4 БОС-ын болон Ойн газрын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсгүүд журам, зааврыг боловсруулан гаргах, батлуулах ажлыг зохион байгуулж ирсэн ч ажлын үр дүнг дүгнээгүй, зарим аймагт хуулийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулаагүй байна. Тухайлбал,

- Дархан-Уул, Өвөрхангай, Хөвсгөл аймагт хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулаагүй байна.
- Орхон аймгийн ИТХ-ын 2007 оны 1 дүгээр тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны аймгийн хөтөлбөр”-д илэ холбогдолтой 5 аргаар орсон бөгөөд илэ баг аааааа, сг бөлнө иэ аа өаааа, и°оо и нүдүүү, гдээгдүүү аааа оүй аяуу еэ о аааааа о и ай дд и сг ддөө тусгагдаагүй аааи а. Мөн ойн сангийн бүрэн мэдээлэлгүйгээс ойг хамгаалах, зохистой

аө өөаөаө, і°оі нүдәүүө, үдәүүө адаа оуи әууи өө үд і°ө°ө үе аі аөі аи а хуулийн дагуу хэрэгжүүлж чадаагүй байна.

Хууль хэрэгжүүлэх талаар хурал, зөвлөгөөнөөр авч хэлэлцсэн боловч ажлын үр дүн харагдахгүй байна

1.5 БОЯ-наас 2007, 2008 онд Дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, ГТХАН-ийн төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хууль сурталчлах сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг 4-5 удаа зохион байгуулжээ.

1.6 БОАЖС-ын 2008 оны 72 дугаар тушаалаар 2009 оныг байгаль хамгаалагчдыг чадавхижуулах жил болгон зарлаж, 21 аймаг, нийслэлд “Байгаль орчны ажилтнуудын орон нутгийн зөвлөгөөн”-ийг аймаг, нийслэлийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулжээ.

1.7 Дэлхийн банкнаас хэрэгжүүлсэн “Ой бүхий газар нутгийг хамгаалах төсөл”-ийн санхүүжилтээр Ойн газраас 2009 оны 3 дугаар сарын 10-11-нд аймгуудын БОАЖГ-ын болон Ойн нэгжийн дарга, мэргэжилтнүүд оролцсон “Ойн тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээ” зөвлөгөөнийг нийслэлд зохион байгуулжээ.

1.8 БОАЖЯ, Ойн газраас 2009 онд ГТХАН-ээс хэрэгжүүлж буй “Байгаль хамгаалал, байгалийн нөөцийн тогтвортой менежмент төсөл”-тэй хамтран 4 бүсэд “Ойн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх нь” сэдэвт зөвлөгөөн хийжээ.

1.9 БОЯ “Байгаль орчны төлөв байдлын 2006-2007 оны тайлан”-г Засгийн газрын 2008 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хуралдаанд танилцуулсан ч ямар нэг шийдвэр гараагүй байна.

1.10 Ийнхүү хууль сурталчлах сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг гадаадын байгууллага болон төслийн дэмжлэгтэйгээр цөөнгүй зохион байгуулсан боловч ажлын бодит үр дүн гараагүй байна.

Зарим аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нар бүрэн эрхээ хэрэгжүүлэхгүй байна

1.11 Шинэчлэн батлагдсан хуулийг хэрэгжүүлэх талаар зарим аймгийн ИТХ, Засаг даргын зөвлөл авч хэлэлцээгүй байна. Тухайлбал,

- Архангай аймгийн ИТХ хуулийн хэрэгжилт, түүнийг эрчимжүүлэх талаар тогтоол шийдвэр гаргаагүй, Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан асуудлыг аймгийн ИТХ-аар авч хэлэлцсэн баримт материал байхгүй, энэ талаар бодит ажил хийгдээгүй, ойн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар Засаг даргын захирамж гарган сумдад хүргүүлсэн боловч түүний мөрөөр авсан арга хэмжээ, хийсэн ажлыг аймгийн БОАЖГ дүгнэж, тодорхой ажил хийгээгүй байна.
- Булган аймгийн ИТХ Засаг даргын мэдээлэл, тайланг сонсоогүй, ойг хамгаалах талаар 2007, 2008 онд ямар нэг шийдвэр гаргаагүй.
- Өвөрхангай, нийслэлийн ИТХ 2008-2009 онд хуулийг хэрэгжүүлэх, ойн сангийн төлөв байдал, мэдээллийн сангийн талаар Засаг даргын тайлан, сонсголыг авч хэлэлцээгүй.
- Нийслэлийн дүүргийн ИТХ, Засаг дарга нар хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах талаар зарим нэг ажил хийсэн боловч ИТХ-д ажлаа тайлагнаагүй, хуулийг хэрэгжүүлэх цогц ажлыг хийгээгүй байна.

Хууль хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээний биелэлтийг дүгнэж, эрчимжүүлэх ажил хангалтгүй байна

1.12 Ойн газраас бүсийн зөвлөгөөний шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, санал шүүмжлэлийн мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөг баталсан ч энэхүү ажлын үр дүн гараагүй байна.

1.13 БОАЖС-ын 2009 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн 243 дугаар тушаалаар байгаль орчны салбарын ажилтнуудын зөвлөгөөний үеэр гарсан санал, шүүмжлэлийн мөрөөр зохиох арга хэмжээний төлөвлөгөөг 100 багц асуудалтай баталсны дотор ойн талаар 16 багц асуудал багтжээ.

1.14 “Ойн хууль, тогтоомжийг эрчимжүүлэх нь” сэдэвт бүсийн зөвлөгөөний шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор ойн менежментийн төлөвлөгөөний, ойгоос мод бэлтгэх, арчилгаа, цэвэрлэгээний ажлын гүйцэтгэлийн, ойг нөхөн сэргээх, үржүүлэх, ой хамгааллын, орон нутгийн ойн байгууллагын бүтцийн, боловсон хүчнийг чадавхижуулах, сургалт сурталчилгааны гэсэн 6 бүлэг асуудлыг багтаасан хөтөлбөр боловсруулжээ.

1.15 Хөтөлбөрийг 2009 онд багтаан хэрэгжүүлэхийг 16 аймгийн БОАЖГ-т, хамтран хэрэгжүүлэхэд дэмжлэг авч болохуйц хандивлагч байгууллагыг сонгож ажиллахыг Ойн газрын холбогдох хэлтэст даалгасан боловч хэрэгжилт хангалтгүй байна.

1.16 Хуулийг хэрэгжүүлэх асуудлыг ийнхүү хурал зөвлөгөөнөөр хэлэлцэж, ажлын төлөвлөгөө гаргасан боловч ажлын явц удаашралтай, ажлын хэсгүүд ажлаа дүгнэж ажиллаагүй байна.

1.17 Орон нутагт хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байгаа боловч үр дүн нь харагдахгүй байна. Тухайлбал, Архангай, Булган, Өвөрхангай, Орхон, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий аймгийн ИТХ, Засаг дарга хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар шийдвэр гаргасан боловч биелэлтийг дүгнэх, хяналт тавих, хариуцлага тооцох ажлыг хийгээгүй байна.

Бүлэг 2. Хуулийг иргэдэд сурталчлах ажлын бодит үр дүн хангалтгүй байна

Ойн тухай шинэчлэгдсэн хууль тогтоомжийг сурталчлах ажил хийгдэж байгаа боловч үр дүн харагдахгүй байна

2.1 Шинэчлэн батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх талаар БОАЖЯ-наас зохион байгуулсан бодитой ажил алга байна.

2.2 Аймаг, нийслэлд хуулийг сурталчлах арга хэмжээг хэрэгжүүлж байгаа боловч үр дүнг хэлэлцэж дүгнээгүй, сургалт сурталчилгаанд бүрэн хамрагдаагүй, хууль сурталчлах ажлыг эрчимжүүлэх тодорхой ажил хийгдээгүй байна. Тухайлбал,

- Сэлэнгэ, Архангай, Булган аймагт хуулийг сурталчлах ажил хангалтгүй зохион байгуулагдсан байна.
- Хөвсгөл аймагт сурталчилгааны ажил хийсэн гэх боловч үр дүнг тооцоогүй байна.

2.3 БОЯ, Ойн хэрэг эрхлэх газраас 2007-2008 онд иргэд, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад шинэчлэгдсэн хуулийг сурталчлах ажил хийгээгүй байна.

2.4 Ойн газар шинэчлэгдсэн хууль тогтоомжийг сурталчлах ажлыг 2008 оны 11 дүгээр сараас зохион байгуулж иржээ. Тухайлбал,

- МҮОНРТ-ээр Ойг хамгаалах иргэний эрх, үүргийг олон нийтэд сурталчлах зорилгоор хууль бус мод бэлтгэлийн талаар 40 минутын захиалгат нэвтрүүлэг, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх талаар “Монголын шинжлэх ухаан, танин мэдэхүй, байгаль орчны кино нийгэмлэг”-тэй хамтран сэрэмжлүүлэг сурталчилгааг мөн телевизээр 2 сарын хугацаанд, TV-9 телевизээр бүх нийтээр мод тарих хөдөлгөөний хүрээнд ойжуулалтын ажлын талаар цуврал нэвтрүүлэг явуулсан.
- “Ой ашиглалт, ойжуулалтын өнөөгийн байдал”, ойн тухай хууль тогтоомжийн талаар Монголын үндэсний радио болон, Өдрийн сонинд 2 удаагийн ярилцлага өгсөн.
- “Мод тарихад ч тайрахад ч бодлого хэрэгтэй”, “Түлээний модонд төрийн бодлого үгүйлэгдэж байна”, “1990 оноос хойш зах зээлд хөрвөөгүй салбар бол ОЙ” гэсэн нийтлэл-ярилцлага Улаанбаатар, Өнөөдөр, Өдрийн сонинд тус тус хэвлүүлсэн.
- Мод тарих хялбаршуулсан аргачлал, ойн түймрээс сэргийлэх талаар зурагт хуудсаар, “Ойжуулалтын ажлын арга технологи”, “Ой хээрийн түймрээс сэргийлэх, тэмцэх арга” ном хэвлүүлэн БОАЖЯ, Ойн газраас зохион байгуулсан зөвлөгөөн, сургалт семинарын үеэр БОАЖГ-уудад хүргүүлсэн.

2.5 Аймаг, нийслэл, сум дүүргийн ойн алба, нэгжүүд ойн хуулийг сурталчлах болон мэргэжил арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх ажлыг хийхгүй байна.

Аудитын явцад хуулийн хэрэгжилттэй холбогдуулан Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Ерөө сумын Бугант тосгон, Мандал сумын иргэдээс санал асуулга авлаа.

- Хуулийн сурталчилгаа хэр хийгдэж байна вэ? асуулгад 92 хүн оролцсоноос 55.4 хувь буюу 51 хүн сурталчилгаа бага зэрэг болон огт хийгдээгүй гэсэн хариултыг өгсөн.
- Хуулийг хэрэгжүүлэх талаар иргэн таны оролцоо ямар байна вэ? асуулгад 89 хүн оролцсоноос 66.3 хувь буюу 59 хүн дунд буюу оролцдоггүй гэж хариулсан.¹
- Нийслэлийн БХГ-аас иргэд, ААНБ-д хуулийг сурталчлах ажил хийгээгүй байна.

2.6 Хууль тогтоомжийг иргэд, нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагад сурталчлах ажлыг хийсэн гэх боловч үр дүн гарахгүй байна.

Бүлэг 3. Бүтэц, зохион байгуулалт хийхэд хугацаа алдсан байна

3.1 Засгийн газрын 2006 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчны /хуучин нэрээр/ яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т заасны дагуу тус яаманд Ойн бодлого зохицуулалтын хэлтэс ойн асуудлыг хариуцан ажиллаж байжээ.

Шийдвэрийн огноо, дугаар	Агуулга	Бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд оруулсан өөрчлөлт
Засгийн газрын 2006 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 36 дугаар тогтоол	“Зарим яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр зөвшөөрөх, зохион байгуулалтын бүтэц батлах тухай”	Тогтоолын дагуу зөвшөөрснөөр БОЯ-ны бүтцэд Ойн бодлого зохицуулалтын хэлтэс ажиллаж байжээ.
Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 65 дугаар тогтоол	“Яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, зохион байгуулалтын бүтэц батлах тухай”	Тогтоолын дагуу БОАЖЯ-ны шинэчлэгдсэн бүтцээр 6 газар, 3 хэлтэстэй ажиллах болсноор дээрх Ойн бодлого зохицуулалтын хэлтсийн чиг үүргийг бусад газарт шилжүүлжээ.
Засгийн газрын 2008 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 212 дугаар тогтоол	“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай”	Засгийн газрын 2002 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 162 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт оруулан Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэгч агентлаг болох


¹ Дөрөвдүгээр бүлэг. Иргэн нөхөрлөл аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

Байгаль орчны сайдын 2008 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 226 дугаар тушаал	Дүрэм, хөтөлбөр, бүтэц, орон тоо батлах тухай	Ойн хэрэг эрхлэх газрыг байгуулах, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Ойн хэрэг эрхлэх газрын дүрэм, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөр, газрын бүтэц, орон тоог баталжээ.
Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний 64 дүгээр тогтоол	Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай	Ойн хэрэг эрхлэх газрыг Ойн газар болгон өөрчлөн зохион байгуулж, Ой, усны хайгуул судалгааны төвийг татан буулгаж тус агентлагт чиг үүргийг нь шилжүүлсэн байна
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 86 дугаар тушаал	Дүрэм, хөтөлбөр, бүтэц, орон тоо батлах тухай	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Ойн газрын дүрэм, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөр, газрын бүтэц, орон тоог шинэчлэн баталж Байгаль орчны сайдын 2008 оны 226 дугаар тушаалыг хүчингүй болгожээ.

3.2 Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 65 дугаар тогтоолоор тус яам 6 газар, 3 хэлтэстэй ажиллах болсноор Ойн бодлого зохицуулалтын хэлтсийг татан буулгаж, энэ чиг үүрэг Тогтвортой хөгжил, стратеги төлөвлөлтийн болон Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газарт шилжсэн боловч дээрх газруудад ойн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан ажилтангүй байна.

Ойн газар 2009 оноос үйл ажиллагаагаа эхэлжээ

3.3 Засгийн газрын 2008 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 212 дугаар тогтоолоор БОС-ын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн хэрэг эрхлэх газрыг байгуулсан ба Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 64 дүгээр тогтоолоор Ойн хэрэг эрхлэх газрыг Ойн газар болгон өөрчилжээ. Ой, усны хайгуул судалгааны төвийг татан буулган энэ байгууллагын чиг үүргийг 2009 оны 4 дүгээр сараас Ойн газарт шилжүүлсэн байна.



3.4 БОАЖС-ын 2009 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 86 дугаар тушаалаар тус газрын дүрмийг шинэчилж, бүтцийг 4 хэлтэс, 3 алба, 1 тасаг, нийт 37 орон тоотойгоор баталжээ. Мөн тогтоолыг үндэслэн ОУХСТ-ийн зохион байгуулалтын нэгжид ажиллаж байсан үрийн лаборатори, модлог ургамлын цэцэрлэгийн үйл ажиллагааг Ойн газрын бүтцэд оруулж, одоо тус агентлагт нийт 52 хүн ажиллаж байгаа боловч дотоодын хяналт шалгалтын чиг үүрэгтэй нэгж алга байна.

Аймаг, нийслэлийн БОА-ны бүтцэд ойн асуудал эрхэлсэн нэгж хуулийн дагуу зохион байгуулагдаагүй байна

3.5 Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” 67 дугаар тогтоолоор хэрэгжүүлэгч агентлаг “Байгаль орчин, аялал жуулчлалын газар”-ыг ажиллуулах болжээ.

3.6 Булган, Дорнод, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Хөвсгөл аймгуудын БОАЖГ-т Ойн асуудал хариуцсан нэгж ажиллаж байгаа боловч, Сэлэнгэ, Орхон, Өвөрхангай аймгийн БОАЖГ-ын ойн асуудал эрхэлсэн нэгжийн ажиллах дүрэм, журам, орон тоо бүтэц нь батлагдаагүй байна.

3.7 Зарим аймгийн БОАЖГ-ын бүтэц хуулийн дагуу зохион байгуулагдаагүй байна. Тухайлбал,

- Архангай аймгийн БОАЖГ-т ойн асуудал эрхэлсэн нэгжийг байгуулаагүйгээс хуулийн хэрэгжилтийг хангуулах, түүнд хяналт тавих, удирдлага, арга зүйгээр хангах ажил хангалттай хийгдээгүй,
- Нийслэлийн Байгаль хамгаалах газрын бүтцэд ойн асуудал хариуцсан нэгж байхгүй.

Зарим дүүргийн ойн асуудал эрхлэх нэгжийн бүтэц, зохион байгуулалт хуулийн дагуу хийгдээгүй байна

3.8 Ойн газраас гаргасан судалгаагаар хууль шинэчлэгдэн батлагдсанаас хойш Булган аймгийн Хангал, Дорнод аймгийн Баян-Уул, Завхан аймгийн Тосонцэнгэл, Өвөрхангай аймгийн Бат-Өлзийт, Архангай аймгийн Ихтамир, Эрдэнэмандал, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Ерөө, Мандал, Хүдэр, Төв аймгийн Батсүмбэр, Мөнгөнморьт, Хэнтий аймгийн Биндэр, Өмнөдэлгэр зэрэг сумдад сумын болон сум дундын нийт 14 ойн анги байгуулагдаад байна. Харин нийслэл, түүний дүүрэгт ойн асуудал эрхэлсэн нэгж зохион байгуулагдаагүй байна.

3.9 Ойн ангийн эрх үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг тодорхой болгохоор ОХЭГ-ын даргын 2008 оны 25 дугаар тушаалаар баталсан “Ойн ангийн үлгэрчилсэн дүрэм”-ийг Ойн газрын даргын 2009 оны 50 дугаар тушаалаар шинэчлэн баталсан боловч бүрэн хэрэгжихгүй байна. Тухайлбал, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Ерөө сум, Бугант тосгоны ойн анги 1 хүнтэй, материаллаг баазын хувьд бүрэн бэхжээгүй, ажиллах чиглэл дүрэмгүй, бүтэц зохион байгуулалт нь батлагдаагүй байна.

3.10 Зохион байгуулагдсан ойн ангиудын үйл ажиллагаанд дор дурдсан зөрчил дутагдал гарч байна. Тухайлбал,

- Сэлэнгэ аймгийн Мандал сумын Засаг даргын 2009 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн “Бүтэц, орон тоо батлах тухай” 54 дүгээр захирамжаар “Байгаль орчны хяналтын тасаг”-ийг баталсан ч тухайн бүтэцэд Байгаль орчны алба, Ойн ангийн бүтэц зохион байгуулалт, орон тоог хамруулаагүй.
- Мандал сумын ойн ангийг бэхжүүлэх зорилгоор ГТХАН-ийн “Байгаль хамгаалал, байгалийн нөөцийн тогтвортой менежмент” төслөөс 16.7 сая төгрөгийн суудлын автомашин, бусад техник хэрэгсэл, эд зүйлийг олгосон боловч Засаг даргын 2009 оны 2 дугаар сарын 84 дүгээр захирамжаар ажлаасаа чөлөөлөгдсөн Ж.Эрдэнэцогт дээрх хөрөнгийг хүлээлгэж өгөөгүй өөрийн мэдэлд ашиглаж байна. Мөн нөхөрлөл, ААНБ болон ойн ангийн үйл ажиллагаатай холбоотой гэрээ, хэлцэл холбогдох бусад баримт материалыг хүлээлгэж өгөөгүй, үнэт цаасны тооцоог хийгээгүй.

- Мандал сумын ойн ангид Архангай аймгаас 2007 онд авсан ЗИЛ-130 машиныг данс бүртгэлд тусгаагүй.
- Архангай аймгийн Засаг даргын 2008 оны 332 дугаар захирамжаар сум дундын ойн ангийг Ихтамир, Эрдэнмандал сумдад байгуулсан боловч ойн ангийн ажиллах журмыг хуульд заасны дагуу батлаагүй, бүтэц орон тоо, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлээгүй, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдээгүй.
- Хөвсгөл аймгийн нэг ч сумын ЗДТамгын газарт ойн асуудал хариуцсан ажилтан байхгүй.
- Нийслэлийн дүүргүүдэд ойн анги зохион байгуулагдаагүй.

Ойн сангийн тодорхой хэсгийг нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх ажлыг хангалтгүй зохион байгуулж байна

3.11 Ойн газраас 2009 оны 9 дүгээр сарын 1-ний байдлаар гаргасан судалгаагаар улһи́ бүй́ æу́й́ ä 325 í ° õ ðлөл 764.5 мянган га ойг эзэмшиж байна.²

3.12 Засгийн газрын 2009 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 227 тогтоолоор “Ойн санг нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх журам”³ баталсан боловч дээрх журмын дагуу шаардлага, нөхцөлийг нь хангасан нөхөрлөл байгуулагдаагүй байна. /Аудитад хамрагдсан ойн нөхөрлөлийн судалгааг Хавсралт 1-ээр үзүүлэв/

3.13 Хууль шинэчлэн батлагдахаас өмнө нөхөрлөл байгуулсан багийн иргэдийн Нийтийн Хурлын материал, тэдний үйл ажиллагаа, сумын ЗД-тай байгуулсан гэрээ хэлцэл, ойн менежментийн төлөвлөгөө, түүнд тусгагдсан асуудлын талаар танилцахад доорхи зөрчил, дутагдал гарч байна. Үүнд:

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгонд нийт 14 ойн нөхөрлөл үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр нөхөрлөлийг анх байгуулсан багийн хурлын материал багийн иргэдийн Нийтийн Хурлын даргад байхгүй, гэрээнд тусгагдсан ойжуулалтыг бүрэн хийсэн, модны үр бэлтгэсэн, ойд арчилгаа цэвэрлэгээний ажлыг гэрээний дагуу хийсэн нөхөрлөл 1-ээс өөр байхгүй.

- Мөн сумын нутагт ойжуулалт хийж тарьц суулгасан талбайд тусгаарлалт хийгээгүй, тэмдэг байхгүй, тарьсан модны 33-66 хувь нь ургаагүй.
- Менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ойжуулалтын мэдээгээр БСУТА-ыг 48 га талбайд хийхээс 3 га-д, 38 кг үр бэлтгэхээс бэлтгээгүй, ой арчилгаа цэвэрлэгээний ажлыг 309 га-д хийхээс 1 л нөхөрлөл хийж байгаа, бусад нөхөрлөл эхлээгүй.

Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын ИТХ-ын тогтоолоор 2008 оноос хойш 10 нөхөрлөл шинээр байгуулагдсан боловч ойн санг гэрээгээр эзэмших гэрчилгээгүй.

Орхон аймгийн Засаг дарга сумын ИТХ-ий а́ждүй́ үддүй́ òäèäàì хууль батлагдснаас хойш “Мандал” нөхөрлөлд 2007 оны 12 дугаар сарын 25, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д мөн оны 7 дугаар сарын 19-ний захирамжаар í éí ñàí ä ãýúýäýú ð ýçì ø ççèýø ø èéäáúð тус тус ääðäàæý.

- Мөн аймгийн БОАЖГ-ын дарга Х.Машбат ойн санг эзэмшүүлэх ямар нэгэн шийдвэр гараагүй байхад “Эрдэнэт үйлдвэр” ХХК-тай 2007 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан гэрээнд тус үйлдвэрийн холбогдох албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдэггүй, хүчин төгөлдөр бус гэрээгээр 9 га талбай эзэмшүүлжээ.
- Орхон аймгийн Жаргалант сумын ИТХ “Урт үүр” нөхөрлөлд ойн санг гэрээгээр эзэмшүүлэх шийдвэр 2007 оны 10 дугаар сарын 8-ны өдөр гарсан байхад ойн санг эзэмших эрхийн гэрчилгээг 2006 оны 3 дугаар сарын 24-ний өдөр олгож байсан.
- Үдäýí ýð õí ò ùí í í äí í í ä çñèéí òèèèéí çàäàèèä ò í äò í í ñí í⁴ шийдвэр гараагүй учраас хотын ойр í ð-í ù í éí ñàí ääàñ ì í ä áýèð äýð ç⁰ äø⁰ ð⁰ è í èäí õ, õóóèü áóñàäð ì í ä áýèð äýð ýäàäè ääçàð ääñàäð õí ò ùí í éðí èõí í х í é õñò äðää õçðсэн.

² Эх сурвалж: Ойн газар, Ой ашиглалтыг зохицуулах хэлтэс

³ 4.4.2.сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн ойн сангийн тодорхой хэсгийг тогтоосон хугацаа, нөхцөл, болзолтойгоор гэрээний дагуу нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад.

⁴ 8.5.2.нийслэлээс бусад хотын 30 хүртэл километрийн доторхи ногоон бүсэд хамаарах ойн заагийг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага,

2008 онд Нийслэлийн ногоон бүсэд хийсэн ойн зохион байгуулалтын ажлын тайланд ойн сангийн талбайг 266.9 мянган га гэж тогтоосон нь 1998 онд хийгдсэн тайланд дурьдсанаас 151.0 мянган га талбайгаар нэмэгдсэн байна. Энэ нь Засгийн газрын 1996 оны 326 дугаар тогтоолоор нийслэлийн хилийн цэсийг 540.0 га гэж тогтоож Төв аймгийн Батсүмбэр, Эрдэнэ сумын нутгийн ойн сангийн талбайгаас оруулан тооцсонтой холбоотой байна.

■ Нийслэлийн ногоон бүсийн ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшүүлэх зорилгоор ойн сан бүхий 6 дүүргээс Сүхбаатар, Налайх дүүргүүд зохих шийдвэр гаргаж 7 нөхөрлөлд нийт 11306 га талбайг хариуцан хамгаалуулах гэрчилгээ олгосон боловч эдгээрээс хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа нөхөрлөл алга байна. БЗД, СХД, ХУД, ЧД энэ талаар ажил зохион байгуулаагүй.

Хөвсгөл аймгийн 12 суманд 43 нөхөрлөл байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа мэдээ гарсан боловч бодит байдалд (ИТХ, ИНХ-ын тогтоол гараагүй) үйл ажиллагаа явуулж байгаа нэг ч нөхөрлөл байхгүй, тэдгээрийн эзэмшилд ойн санг шилжүүлээгүй байна.

3.14 Ойн газраас гаргасан судалгаагаар Сэлэнгэ аймагт 25, Төв аймагт 11, Увс аймагт 3, нийт 39 ААНБ 226.4 мянган га талбайг гэрээгээр эзэмшиж байна. Эдгээр нэгжийн ихэнх нь хууль шинэчлэн батлагдахаас өмнө байгуулагдсан бөгөөд “Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журам”-ын дагуу ажиллаж байгаа ААНБ алга байна. /Хавсралт 2-ыг үзнэ үү/

3.15 БОАЖЯ-наас 2008-2009 онд 13 аймаг, нийслэлийн 109 ААНБ-д ойн мэргэжлийн байгууллагын эрх олгосон байна. Эдгээрээс ойжуулалтын 16, мод үржүүлэг, ойжуулалтын 66, мод үржүүлэг, ойжуулалт, ой хамгаалалт, ой зохион байгуулалт, хортон шавж устгах чиглэлээр 12, мод үржүүлэг ой хамгаалал, ой зохион байгуулалт, ойн арчилгаа, цэвэрлэгээ хийх чиглэлээр 15 байгууллагад эрх олгож, сүүлийн 2 жилд ой ашиглалтын чиглэлээр эрх олгоогүй байна.

3.16 Ойн санг гэрээгээр эзэмшиж ирсэн болон БОЯ-наас мэргэжлийн байгууллагын гэрчилгээ авсан зарим ААНБ-ын үйл ажиллагаатай танилцахад мэргэжлийн байгууллагын гэрчилгээгүй, гэрчилгээний хугацаа дууссан, гэрээний үүргээ биелүүлээгүй, ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа явуулах чиглэл, заалтыг зөрчиж мод бэлтгэх ажиллагаа явуулж байгаа зөрчил илэрч байна.

Тухайлбал,

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгонд мэргэжлийн байгууллагын гэрчилгээгүй:

- “Бумбат мөнгөлөг” ХХК-ийн гэрчилгээний хугацаа 2008 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр дууссан атал 2008 онд 400 м³, 2009 онд 1000 м³ мод бэлтгэх гэрээ хийж бэлтгэж байна.
- “Мөнгөлөг хайрхан” ХХК-ийн гэрчилгээний хугацаа 2008 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр дууссан. Гэрчилгээгээр тус компани нь “Ойжуулалт, ойн цэвэрлэгээ”-ний ажил эрхлэх ёстой атал мод бэлтгэлийн ажиллагаа явуулж, 2008 онд 300 м³ мод бэлтгэж, улмаар 2009 онд 1000 м³ мод бэлтгэх гэрээ хийж бэлтгэж байна.
- “Мөнгөлөгийн зоо” ХХК мэргэжлийн байгууллагын гэрчилгээ байхгүй, /хугацаа дууссан/ сунгуулахаар өгсөн гэж тайлбарласан. 2008 онд 400 м³ мод бэлтгэж, 2009 онд 1000 м³ мод бэлтгэхээр гэрээ хийгджээ.
- “Тайлчийн нуруу” ХХК мэргэжлийн байгууллагын гэрчилгээ байхгүй, хугацаа дуусаж сунгуулахаар өгсөн гэж тайлбарлаж байна. Гэтэл 2008 онд 450 м³ мод бэлтгэсэн, 2009 онд 1000 м³ мод бэлтгэхээр гэрээ хийгдсэн байна.
- “Хайрхан буянт” ХХК мэргэжлийн байгууллагын гэрчилгээ нь 2008 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр хугацаа дууссан, “Ойжуулалт, ойн цэвэрлэгээ” гэсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулах ёстой атал 2008 онд 1100 м³ мод бэлтгэсэн, 2009 онд 909 м³ мод бэлтгэх гэрээтэй. ИТХ-ын шийдвэр нь 899 м³ бэлтгэх ёстой атал 10 м³-ээр илүү гэрээ хийн мод бэлтгэж байна.

Аж ахуйн нэгж, байгууллагын мэргэжлийн байгууллагын гэрчилгээний заалт зөрчигдсөн:

- “Түнхэл-Итэм” ХХК-ийн гэрчилгээнд “Мод үржүүлэг, ойжуулалтын үйл ажиллагаа эрхлэх” гэсэн заалттай атал мод бэлтгэх үйл ажиллагаа эрхэлж байна. Тус компани 2008 он 450 м³ мод бэлтгэж, 2009 онд үйлвэрлэлийн зориулалтаар 1000 м³ мод бэлтгэх гэрээг байгуулсан.

- “Хангайн бүргэд” ХХК-ийн гэрчилгээ “Ойжуулалтын ажил эрхлэх” гэсэн заалттай. 2008 онд 400 м³ мод бэлтгэж, 2009 онд 1000 м³ мод бэлтгэх гэрээ хийсэн.
- “УБЦО” ХХК “Ойжуулалтын ажил эрхлэх” чиглэлтэй атал мод бэлтгэлийн үйл ажиллагаа эрхэлж 2008 онд 400 м³ мод бэлтгэсэн бөгөөд 2009 онд 1042 м³ мод бэлтгэхээр гэрээ хийсэн.
- “Хүдэр хайрхан” ХХК-ийн гэрчилгээ “Ойн арчилгаа цэвэрлэгээ, мод үржүүлэг, ойжуулалтын ажил эрхлэх” чиглэлтэй. Гэтэл 2008 онд 400 м³ мод бэлтгэсэн бол 2009 онд үйлдвэрлэлийн зориулалтаар 1000 м³ мод бэлтгэхээр гэрээ хийжээ.

Дээрх ААНБ-ын менежментийн төлөвлөгөөгөөр 2008 онд 102.5 га-д ойжуулалт хийхээс 19.5 га-д 2009 онд 196 га-д хийхээс 86 га-д хийсэн гүйцэтгэл гарч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүй байна.

Мандал суманд энэ байдал давтагдаж байна. Үүнд:

- “Хандгайннуур” ХХК-ийн гэрчилгээнд “Мод үржүүлэг, ойжуулалт” хийхээр заагдсан байтал 2009 онд 1000 м³ мод бэлтгэх, (ЗД-ын цохолтоор 400 м³ мод бэлтгэх зөвшөөрлийг нэмж олгосон)
- “Минж даваа” ХХК-ийн гэрчилгээнд “Мод үржүүлэг, ойжуулалтын ажил эрхлэх” ёстой атал 2009 онд 1000 м³ мод бэлтгэх.
- “Мандал оргил” ХХК “Мод үржүүлэг, Ойжуулалт” чиглэлээр үйл ажиллагаа явуулах ёстой атал 2009 онд 1000 м³ мод бэлтгэх.
- “Ачитхараа” ХХК “Мод үржүүлэг, Ойжуулалт” чиглэлтэй боловч мод бэлтгэж, хөрөө рам ажиллуулан 2009 онд 1500 м³ мод бэлтгэх.
- “Цогтманлай” ХХК “Мод үржүүлэг, ойжуулалт” гэсэн чиглэлээр эрх авсан гэх атал 2008 онд 260 м³, 2009 онд 2500 м³ мод бэлтгэх,
- “Мортир” ХХК 1000 м³, “Маргад хараа” ББН 1000 м³, “Хараа инвест” ХХК 1000 м³, “Номголжин” ХХК 1500 м³ мод бэлтгэх зөвшөөрөл тус тус авсан байна.

Сэлэнгэ аймгийн Мандал сум, Түнхэл тосгоны ААНБ-уудад сумын ИТХ-ын дарга Ц.Эрдэнэчимэг, Засаг дарга Б.Цээпилдорж нарын шийдвэрээр мод бэлтгэх гэрээ байгуулах эрх олгосон байна. Тухайлбал,

- “Очир-Эрдэнэ” ХХК-ийн хүсэлтэд 200 м³ мод бэлтгэх.
- Говьсүмбэр аймгийн засаг даргын хүсэлтийг үндэслэн иргэн Ч.Чинзоригт 200 м³ модны зөвшөөрлийг тус тус олгосон байна.

Алтанбулаг сумын 5 ААНБ ойн менежментийн төлөвлөгөөгөө БОАЖГ-аар батлуулаагүй, мэргэжлийн байгууллагын гэрчилгээгүй байхад ИТХ-аас ойн санг эзэмшүүлсэн байна.

Ерөө сумын Бугант тосгонд мөн адил зөрчил гарлаа. Үүнд:

- “Алтан Со Лин” ХХК-д БОЯ-наас олгогдсон 105/2007 дугаартай мэргэжлийн байгууллагын гэрчилгээнд “ойн арчилгаа, цэвэрлэгээ, мод үржүүлэг, ойжуулалтын ажил эрхлэх” гэж бичигдсэн атал ямар ч ажил хийгдээгүй, 2009 онд 600 м³ мод бэлтгэхээр гэрээ хийж бэлтгэж байна.
- Бугант групп /5 ААН/ 2008 онд хийсэн гэрээнийхээ дагуу мод бэлтгэлийн ажлын гүйцэтгэлийг дүгнэж ажиллаагүй байна.

БОАЖЯ-наас 2009 оны 10 дугаар сарын 14-ны өдөр ирүүлсэн албан бичигт Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Видовүүд” ХХК, “Очир-Эрдэнэ манлай” ХХК, “Идэр мандал” хоршоо, Түнхэл тосгон дахь “Тайлчийн нуруу” ХХК-д мэргэжлийн байгууллагын гэрчилгээ олгосон тушаал болон гэрчилгээний хуулбар тус яамны 2006-2009 оны архивын баримтад байхгүй гэж тодорхойлсон байна.

Булган аймагт хэрэглээний мод бэлтгүүлэхээр сонгон шалгаруулсан 23 аж ахуйн нэгж, байгууллагаас 16 нь ойн мэргэжлийн байгууллагын эрхгүй байна.

Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗД нар хуульд заасан баримт бичгийн бүрдлийг хангаагүй ААНБ-д ойн санг эзэмшүүлэх гэрээ байгуулж гэрчилгээ олгосон байна.

Ойн газраас 2009 оны 9 дүгээр сард Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгонд хийсэн шалгалтаар дээр дурдсан зөрчил гарч байсны дотор байгаль орчны улсын байцаагч ажилладаггүй, ойжуулалтын ажил эрхлэх 11, мэргэжлийн байгууллагын гэрчилгээгүй 8 ААНБ-д нийт 5260 м³ мод бэлтгэх зөвшөөрлийг Сэлэнгэ сумын ИТХ-аас олгосон байна.

3.17 Ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавиагүй, хуульд заагдсан чиг үүргээ⁵ биелүүлээгүй атлаа орон нутгийн ИТХ, Засаг дарга нар мод бэлтгэх эрх олгож байна.

3.18 БОАЖС, нийслэлийн Засаг даргын 2008 оны 186/234 дугаар тушаал, захирамжаар нийслэлийн ногоон бүсээс мод бэлтгэх болон ой цэвэрлэгээний ажлыг 2 жилийн хугацаагаар түр зогсоож, гэр хорооллын модны хэрэгцээг Сэлэнгэ аймагтай гэрээ хийн бэлтгүүлэхийг дүүргийн Засаг дарга нарт даалгасан боловч биелэгдээгүй, гэр хорооллын түлшний хэрэгцээг хэрхэн хангах талаар нэгдсэн бодлогогүй байгаагаас хууль бусаар түлшний мод бэлтгэх зөрчил арилахгүй байна.

Бүлэг 4. Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагуудаас гаргах журам, заавар бүрэн гараагүй байна

Хуулийн дагуу гаргах 3 журам, зааврыг боловсруулаагүй байна

4.1 Засгийн газар, БОЯ, Ойн газраас 12 заавар, журам гаргахаас аудитыг төлөвлөж байх үед (2009 оны 4 дүгээр сард) Засгийн газрын 1 тогтоол, БОАЖС-ын 1 тушаалаар 2 журам батлагдсан байсан бол аудитын гүйцэтгэлийн явцад батлагдсан 7, хэлэлцүүлгийн шатанд 2, боловсруулагдаагүй 3 заавар журам байна.

Хуулийн дагуу гаргах заавар журмын батлагдсан байдал			
Байгууллага	Батлагдсан /хуулийн заалт, огноо/	Хэлэлцүүлэгт /хуулийн заалт/	Боловсруулаагүй /хуулийн заалт/
Засгийн газраас	1 “Ой зохион байгуулалт хийх” (Хуулийн 7.5, 2008.03.05, №85)	1 “Ойд үзүүлэх хортой нөлөөллийг багасгасан, түүнчлэн дэвшилтэт арга технологи нэвтрүүлсэн иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулах” (Хуулийн 34.1)	1 “Иргэн, ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын мод ашигласны төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх” (Хуулийн 34.3)
	2 “Ойн сангийн тодорхой хэсгийг нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх” (Хуулийн 4.9, 2009.07.22, №227)		
Төрийн захиргааны төв байгууллагаас	3 “Ойжуулалт, ойн аж ахуйн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” (Хуулийн 27.5, 2008.02.28 89/35, 90/36)	2 “Ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх тухай гэрээ, гэрчилгээний загвар батлах” (Хуулийн заалт 19.3)	2 “Усны хагалбар дахь байгаль орчны тэнцлийг хангах, хөрсний эвдрэлээс сэргийлэх зорилгоор цармын бүслүүрийн ойн заагийг тогтоох” (Хуулийн 8.3)
	4 “Мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх” (Хуулийн 6.2, 2009.07.16 №189)		
	5 “Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх” (Хуулийн 25.4, 2009.07.16 №190)		
	6 “Гарал үүслийн гэрчилгээний загвар, түүнийг олгох” (Хуулийн 31.5, 2009.05.20 №128)		
	7 “Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд явуулах, арга зүйн зөвлөгөөгөөр хангах эрхийг холбогдох хуулийн дагуу авсан байгууллагын ажиллах” (Хуулийн 20.3, 2009.10.23 №307)		
8 “Ойн дагалт нөөцийг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааг зохицуулсан” (Хуулийн 32.5, 2009.09.02 №240)	3 “Ойн тухай хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, буюу илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэнд урамшуулал олгох болон Хууль бусаар бэлтгэж хураалгасан гуалин, шургааг, дүнс, зүсмэл материал зэрэг мод, модон материал, түүнчлэн дагалт нөөцийн борлуулалтын орлогын 15 хувийг тухайн зөрчлийг илрүүлсэн улсын байцаагчид олгох” (Хуулийн 34.6)		
Ойн газраас	9 “Ойн менежментийн		

⁵ Ойн тухай хуулийн 15, 16 дугаар зүйл

төлөвлөгөөний үлгэрчилсэн
загвар” (Хуулийн 13.3.12,
2009.06.24 №70)

4.2 Шинэчилсэн хуулийн дагуу гаргах ёстой 3 журам зааврыг боловсруулж батлуулаагүй шалтгааныг Ойн газраас дараахь байдлаар тайлбарлаж байна. Үүнд:

- 8.3-т заасан журмыг БОС-ын 2007 оны 264 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн боловсруулж батлуулах шаардлагатай журам, зааврын жагсаалтад ороогүй байсан, БОС-ын 1998 оны 18 дугаар тушаалаар баталсан журмыг одоо мөрддөг, судалгаа шинжилгээ явуулсны үндсэн дээр өөрчлөх шаардлагатай эсэхийг тогтоох,
- 34.6-д заасан журмыг шинэчлэх шаардлагагүй, Сангийн сайд, Байгаль орчны сайдын 2006 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 342/366 тоот тушаалаар баталсан журмыг мөрдөж байгаа, өөрчлөх шаардлагагүй.

4.3 Харин Ойн тухай хуулийн 34.3-т заасан журмыг боловсруулж гаргаагүй нь Засгийн газрын 2005 оны 147 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан төлбөрийг хэвээр мөрдөж байгаа, өөрчлөх шаардлагагүй гэсэн нь бодит байдалтай нийцэхгүй байна.

4.4 Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ойд арчилгаа болон цэвэрлэгээний аргаар хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг хөнгөлөх хувь хэмжээг заасан байна. Шинэчилсэн хуулийн дагуу ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын мод ашигласны төлбөрийн хөнгөлөлтийн хувь хэмжээг тогтоох заалт бөгөөд энэ нь ойн санг гэрээгээр эзэмшигчид үзүүлэх эдийн засгийн гол хөшүүрэг юм.

4.5 Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын болон Ойн хэрэг эрхлэх газрын бүтэц зохион байгуулалт, ойн асуудал хариуцсан газар хэлтсүүд ойр ойрхон өөрчлөгдөж шинэчлэгдсэн, яаманд энэ асуудлыг хариуцсан ажилтангүй болсон зэргээс шалтгаалан ойн хуулийг хэрэгжүүлэх ажил эзэнгүйдэж, журам, заавар боловсруулж батлуулах ажил хугацаа алдаж удааширсан байна.

Ойн менежментийн улсын ерөнхий төлөвлөгөө хийгдээгүй, аймаг, нийслэлийн төлөвлөгөө бүрэн боловсруулагдаж дуусаагүй байна

4.6 Хуульд зааснаар "Ойн менежментийн төлөвлөгөө" гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн ойн аж ахуйн арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг цогц байдлаар, тодорхой үе шаттайгаар тусгаж, төлөвлөсөн баримт бичгийг хэлж байна. Гэтэл энэ баримт бичгийг хуулийн дагуу боловсруулж батлуулаагүй зөрчил гарч байна. Тухайлбал, Ойн менежментийн Ерөнхий төлөвлөгөөг Байгаль орчны яам боловсруулж, хуулийн дагуу Засгийн газраар батлуулж, хэрэгжилтийг нь зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих ажил хийгдээгүй байна.

4.7 Аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг ойн мэргэжлийн байгууллага боловсруулж, салбар хариуцсан яам⁶ батлах ажил бүрэн хийгдээгүй. Тухайлбал,

⁶ 12.1.6. аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах;

2009 оны 10 дугаар сарын 15-ны байдлаар улсын хэмжээнд ой бүхий нийт 15 аймгийн 178 сумын ойн менежментийн төлөвлөгөө хийх ажлын явц 67.4 хувьтай байна. Үүнээс:

- Архангай аймгийн 15, Баян-Өлгий аймгийн 10, Булган аймгийн 12, Дархан-Уул аймгийн 2, Орхон аймгийн 2, Өвөрхангай аймгийн 5, Төв аймгийн 6, Хөвсгөл аймгийн 22, Хэнтий аймгийн 11, нийт 9 аймгийн 85 сумын ойн менежментийн төлөвлөгөө батлагдсан.
- Дорнод аймгийн 6, Завхан аймгийн 17, Увс аймгийн 12 сум, нийт 3 аймгийн 35 сумын ойн менежментийн төлөвлөгөө хянагдаж байна.
- Архангай аймгийн 1 сум, Говь-Алтай аймгийн 5, Төв аймгийн 16, Баянхонгор аймгийн 5, Завхан аймгийн 2, Өвөрхангай аймгийн 3, Булган аймгийн 3, Сэлэнгэ аймгийн 16 сум, нийт 9 аймгийн 51 сум, нийслэлийн 7 дүүргийн ойн менежментийн төлөвлөгөө хийгдээгүй байна.
- Нийслэлийн ой бүхий СБД, БЗД, ЧД, НД, СХД нутаг дэвсгэрийг ногоон бүсийн ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглахад чиглээдсэн ойн аж ахуйн арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөөтэй байх ёстой атал хийгээгүй, энэ талаар нийслэлийн Байгаль хамгаалах газар ч зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй байна.

4.8 Орон нутгийн БОА-даас ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөл, ААНБ-ын ойн менежментийн төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих ажил⁷ хангалтгүй хийгдэж байна. Ойн газрын судалгаагаар 325 (хавсралтаар) нөхөрлөлөөс Архангай, Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгийн 45 нөхөрлөл “Хамтын оролцооны ойн менежментийн чадавхийг бэхжүүлэх”, “Байгаль хамгаалал, байгалийн нөөцийн тогтвортой менежмент” төслийн дэмжлэгээр менежментийн төлөвлөгөө, ойн тархацын зургаа баталгаажуулсан байна.

Бүлэг 5. Хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн байдал

5.1 Хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төлөвлөхдөө Сангийн сайд, БОС-ын 2008 оны 89/35 дугаар тушаалаар баталсан “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ыг мөрдөж байна.

5.2 БОЯ-наас 2008 онд ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлыг 2170.0 сая төгрөгөөр төлөвлөж УИХ-д оруулсан ба 2576.9 сая төгрөгөөр батлагдсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 1713.9 сая төгрөгөөр, тус яамнаас төлөвлөсөн дүнгээс 406.9 сая төгрөгөөр нэмэгджээ.

5.3 Ойн арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн төлөвлөсөн хэмжээ, батлагдсан байдлыг хүснэгтээр харуулбал:

Санхүүжилтийн төлөвлөлт, хянагдаж батлагдсан байдал (сая төгрөгөөр)							
№	Зардлын нэр	2007 оны		2008 оны		2009 оны	
		Төсөл	Баталсан	Төсөл	баталсан	Төсөл	Баталсан
1	Ойжуулалт	614,0	413,0	846,0	1 056,0	1 980,0	895,5
2	Төвлөрүүлэн хэрэгжүүлэх ойг нөхөн сэргээх	-	-	-	300,0	-	135,5
3	"Ногоон хэрэм" хөтөлбөр	528,0	233,0	572,0	233,0	660,0	116,5
4	Ой зохион байгуулалт	126,0	90,0	144,0	144,0	266,0	228,0
5	ХШӨТ-ын судалгаа, тэмцлийн ажил	190,0	100,0	323,0	685,0	500,0	685,0
6	Ойн АА-н арга хэмжээ	312,0	27,0	285,0	158,9	394,0	230,9
ДҮН		1 770,0	863,0	2 170,0	2 576,9	3 800,0	2 291,4

⁷14.3.9. ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

5.4 2009 онд ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлыг 3800.0 сая төгрөгөөр төлөвлөсөн нь 2291.4 сая төгрөгөөр батлагджээ. УИХ-ын зарим гишүүдийн санал, санаачлагаар ойг нөхөн сэргээх зардлыг 135.0 сая төгрөгөөр, ойн хортон шавжтай тэмцэх ажлыг 185.0 сая төгрөгөөр, бүгд 320.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Ой хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх зориулалтаар олгох хөрөнгийн төлөвлөлт ажлын гүйцэтгэл үр дүнтэйгээ уялдахгүй байна

5.5 Ой хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх арга хэмжээний санхүүжилтийн төлөвлөлт, хянаж баталсан байдлыг сүүлийн 3 жилээр үзүүлбэл:

Арга хэмжээний нэр	2007 оны			2008 оны			2009 оны		
	Хэмжээ /мян.га/	Төсөл /сая.төг/	Баталсан /сая.төг/	Хэмжээ /мян.га/	Төсөл /сая.төг/	Баталсан /сая.төг/	Хэмжээ /мян.га/	Төсөл /сая.төг/	Баталсан /сая.төг/
Ой хамгаалах, бүгд	20.0	210.0	100.0	34.0	433.0	728.9	50.0	670.0	796.0
Үүнээс: ХШӨТэмцэх	20.0	190.0	100.0	34.0	323.0	685.0	50.0	500.0	685.0
Бусад арга хэмжээ	-	20.0	-	-	110.0	43.9	-	170.0	111.0
Нөхөн сэргээх, бүгд	8.0	1257.0	646.0	8.4	1513.0	1629.0	12.1	2705.0	1188.4
Нөхөн сэргээх ажил	8.0	1142.0	646.0	8.4	1418.0	1609.0	12.1	2640.0	1147.5
Бусад	-	115.0	-	-	95.0	20.0	-	65.0	40.9
Үржүүлэх	-	77.0	27.0	-	80.0	95.0	-	159.0	79.0
Нийт дүн	28.0	1 544.0	773.0	42.4	2 026.0	2 452.9	62.1	3 534.0	2 063.4

5.6 Ой хамгаалах арга хэмжээний зардлыг 2008 онд төлөвлөснөөс 295.9 сая, 2009 онд 126.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх арга хэмжээний зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

5.7 2008 онд ойг нөхөн сэргээх ажлын зардлыг 116.0 сая төгрөгөөр, ойг үржүүлэх ажлын зардлыг 15.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан боловч 2009 онд дээрх зардлыг бууруулж баталжээ.

5.8 Ойн арга хэмжээний хөрөнгийн төлөвлөлт, түүнийг баталсан байдлаас харахад ойг хамгаалах буюу хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд илүү анхаарч, ойг нөхөн сэргээх, үржүүлэх арга хэмжээний зардлыг бууруулан баталсан байна. Мөн ойг нөхөн сэргээх ажлыг төлөвлөхдөө зөвхөн тарьц, суулгацын үнийг тооцсон, ойжуулалтын дараах болон ойжуулсан талбайн хамгаалалтын зардлыг тооцоогүй, аймаг, нийслэл, сум, дүүргийн бүрэн төлөвлөлт бодитой хийгдээгүй байна.

5.9 Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ойжуулалт, нөхөн сэргээх, үржүүлэх ажлын гүйцэтгэл үр дүн муутай, гэрээгээ дүгнээгүй, ойжуулалт хийсэн ч тарьц, суулгацын амьдралтын хувь багатай, хариуцлага тооцох арга хэмжээ аваагүй байна.

- 2008 онд Төв аймгийн Мөнгөнморьт суманд нөхөн сэргээлт хийсэн 10 га талбай тэмдэгжүүлэлт хийгээгүйгээс хадланд өртсөн, Жаргалант сумын 70 га талбайд ойжуулалт хийсэн боловч хамгаалалт хийгээгүйгээс тарьц нь ургаагүй тул гүйцэтгэгч байгууллагад өөрийн хөрөнгөөр дахин хийж гүйцэтгэх 12.0 сая төгрөгийн албан шаардлага өгсөн байна.
- Мөн Өвөрхангай аймагт Сангийн сайд, БОС-ын 2008 оны 89/35 дугаар тушаалаар батлагдсан журам⁸ зөрчигдсэн тул 2.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 7.5 сая төгрөгийн албан шаардлага өгсөн байна.

⁸ "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх" журам

- Орхон аймагт ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх зориулалтаар зарцуулах хөрөнгийг төлөвлөхөд шаардлагатай мэдээллийн сангийн үзүүлэлтийг бүрэн хэмжээгээр гаргаж чадахгүй байгаа нь төлөвлөлтийг анхан шатанд үнэлэх боломжийг алдагдуулж ааёгаа тул цаашид арга хэмжээний зардлыг үр дүнгээр санхүүжүүлдэг тогтолцоог судалж хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.

5.10 БОАЖС-ын 2009 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 84 дүгээр тушаалаар зарим жуулчны баазыг тохижуулж, цэцэрлэгжүүлэхэд зориулж 25.0 сая төгрөгийг ойг нөхөн сэргээх ажлын зардлаас гаргахаар шийдвэрлэсний дагуу Монголын жуулчны баазуудын холбоонд “Нэг жуулчин нэг мод” хөтөлбөрийн нэрээр 12.5 сая төгрөгийн урьдчилгаа олгожээ. Тус холбоо нь уг мөнгийг Хэнтийн “Чингисийн тоонот”, Өвөрхангайн “Мөнгөн мод”, Төв аймгийн “Молцог элс”, Өмнөговийн “Говийн гурван тэмээ”, Дундговийн “Онгийн нууц” зэрэг жуулчны 5 баазад (тус бүрт нь 2.5 сая төгрөг) төрөл бүрийн мод тарих зориулалтаар олгосон байна.



5.11 Гэтэл ойг нөхөн сэргээх, үржүүлэхэд зориулан олгосон хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт болон захиалагч, гүйцэтгэгч байгууллагын хоорондын ажлын уялдаа холбоо хангалтгүй, олгосон санхүүжилтийг аймаг орон нутгийн БОАЖГ-т нь мэдэгдээгүйгээс ойжуулах, мод тарих ажлын гүйцэтгэл тайлан мэдээ зөрүүтэй гарч, гэрээнд заагдаагүй газарт ойжуулалт хийсэн зөрчил гарч байна. Тухайлбал,

- Жуулчны баазууд мод тарьсан тухай тайланг ирүүлсэн боловч Ойн газраас дээрх жуулчны баазад ажилласан ажилтнуудын тайланд зарим жуулчны баазад ойжуулалт хийгдсэн, мод тарьсан байдал харагдаагүй, гэрээний дагуу ажил хийгдээгүй, тарьсан суулгацыг хүлээж авсан акт байхгүй гэж дүгнэсэн, Дундговь, Төв аймгийн Байгаль орчны байцаагч нарын тодорхойлсноор тарьсан модны амьдралтын хувь 60-70.8 хувьтай байна.
- “Говийн гурван тэмээ”, “Мөнгөн мод”, “Молцог элс” жуулчны баазууд Ойн газрын ажилтнууд болон байгаль орчны байцаагчдын гаргасан дүгнэлтийг үл зөвшөөрч тайлбар гаргаж, ойжуулалтын ажлын гүйцэтгэлийг хүлээж авсан акт, хийсэн ажлын тайланг фото зураг, тайлбартай ирүүлсэн юм.

5.12 БОАЖС-ын 2009 оны 84 дүгээр тушаалын дагуу санхүүжиж буй дээрх ажиллагаа нь ойжуулах, үржүүлэх зориулалттай мэт боловч төрийн бус байгууллагыг ивээн тэтгэсэн, тэдгээрийг тохижуулах, цэцэрлэгжүүлэхэд зориулагдсан нь төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр нөлөөтэй зарцуулах зарчимд нийцэхгүй байна. Иймд олгогдоогүй үлдсэн 12.5 сая төгрөгийн санхүүжилтийг зогсоох шаардлагатай байна.

5.13 БОАЖС-ын 2008 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 86 дугаар тушаалаар “Чойр Эко парк” төслийн Монголын талын санхүүжилтэд зориулж 30.0 сая төгрөгийг олгожээ.

5.14 “Туул Ротари Клуб” 2007-2009 онд “Чойр Эко Парк” төслийн хүрээнд Говьсүмбэр аймгийн Чойр хотоос 7 км газарт 48 га талбайд салхинаас хамгаалах

ойн зурвас бүхий мод, бут, сөөг, эко парк байгуулах, гүний 3 худаг гаргах ажлыг олон улсын “Ротари” байгууллагаас санхүүжүүлж ирсэн атал төслийн хүрээнд ажиллагсдын цалин, томилолтын зардалд уг мөнгө зарцуулагдсан байна.

5.15 Гэтэл дээрх ажлыг хийж гүйцэтгэх болон Монголын талаас хийх санхүүжилтийн талаар Засгийн газрын хэмжээнд хийгдсэн албан ёсны гэрээ хэлцэл алга байна.

5.16 Мөн ойн зурвас бүхий мод, бут сөөг тарих ажил хийгдсэн боловч ажлын үр дүн хангалтгүй байна. Тухайлбал, Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2009 оны А/325 дугаар захирамжаар томилогдсон тооллогын комиссын 2009 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн тооллогын актаар 7 төрлийн 47000 ширхэг мод тарьснаас




28224 ширхэг нь ургаж, 18776 ширхэг мод үхэж, модны амьдралтын хувь 60.1 хувь болохыг тогтоожээ. Үүнээс шар хуайс, чацаргана, говийн ховор мод зэрэг модны амьдралтын хувь 18.5-27.3 хувь байна.

5.17 Үүний зэрэгцээ гэрээ ёсоор 3 гүний худаг гаргасан боловч 2 нь ажилгүй, (зөвхөн энэ 2 худагт 25.9 мянган ам.доллар зарцуулсан), 3 дахь нь муу ажиллаж байна.

5.18 “Туул Ротари Клуб” ТББ нь НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн дагуу тайлан тэнцэл гаргаагүй, ажиллагсдад олгосон цалин, хөдөлмөрийн хөлснөөс хувь хүний орлогын албан татварыг суутгасан боловч суутгалыг төсөвт шилжүүлээгүй 2.9 сая төгрөгийн зөрчил гаргажээ.

5.19 Ойжуулалтын арга хэмжээнд зарцуулагдаж байгаа хөрөнгийг олон газарт бага багаар тараахгүйгээр жил бүр тодорхой газрыг бүсчлэн сонгож зарцуулвал үр ашгартна, бусад аргаар хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх зориулалтаар зарцуулах хөрөнгийн хэмжээг аймаг, нийслэлд хуваарилсан байдлыг харуулбал, (сая төгрөгөөр):



óðáóóèàòáà чиглүүлж, үүний тулд энэхүү арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх журмыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Ой зохион байгуулалтын санхүүжилтийг бодитой төлөвлөөгүй байна

5.21 Хуулийн 3.1.13-т “ойн талбай, нөөц, тархац, бүрэлдэхүүний хэмжээ, чанар, төлөв байдал, өөрчлөлтийг судлан тогтоож, ойн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг цогц байдлаар тодорхойлох үйл ажиллагааг” ой зохион байгуулалт гэж тодорхойлсон.

5.22 Улсын ойн сангийн нийт 18.8 сая га талбайд хуулийн 7.2 дахь заалтын дагуу æèä 1.9 ñäý ãа-гаас доошгүй òèèáèèä зохион байгуулалт хийгдэх ёстой. Í é çì òèìí ààèãóóèàèòùí àæùã 1990 íííñ ýòèýí гүйцэтгэж 2005 онд í é áçòèè аймгий (çàà áçòèè àèì ãàñ áóñàà) íén санд ой çì òèìí ààèãóóèàèòùí àæùã áóñãæ 2006 íííñ Çààòáí àèì ãàñ ýòèýí ààòòáí ýáóóèè байна.

5.23 Зохион байгуулалтын ажилд шаардагдах хөрөнгийг талбайн хэмжээнд суурилан төлөвлөж байгаа бөгөөд 2007-2009 оны байдлаар авч үзвэл:

1.ОЙ						
Д.д	Áèí àèéí í ýð	Зí òèí í бáèáóóèñ	Тáèááè /í ýí .àà/	Эзлэх хувь	Зардал /сая.төг/	
1	Архангай	2008	1 008.6	7.1	86.9	
2	Баян-Өлгий	2008	68.1	0.5	4.5	
3	Булган	1997-1999	1 982.9	13.9	57.8	
4	Баянхонгор	2006	23.7	0.2	0.9	
5	Говь-Алтай	2005	8.8	0.1	0.6	
6	Дорнод	2006	188.8	1.3	6.0	
7	Төв	2007	1 445.3	10.2	78.1	
8	Хэнтий	2004-2005	1 783.9	12.5	107.0	
9	Завхан	2006	777.9	5.5	60.0	
10	Увс	2002	185.6	1.3	9.0	
11	Сэлэнгэ	1993-1996	2 225.6	15.7	185.2	
12	Í òòí í	2001	21.0	0.1	2.8	
13	Өвөрхангай	2008	171.1	1.2	14.7	
14	Хөвсгөл	2000-2003	4 209.0	29.6	181.2	
15	УБ Ногоон бүс	2008	116.0	0.8	20.0	
Í éí ò àèááè			14 216.3	75.4	814.7	
2.ЗАГ						
1	Õí áä	1991	644.4	13.9	0.7	
2	Áí áí-Áèò áè	1991	1 925.7	41.6		
3	á í í °áí áü	1991	1 173.9	25.3		
4	á á° òòáí áäè	1991	75.8	1.6		
5	Àäýí òí í áí ò	2006	560.7	12.1		19.0
6	Áí òí í áí áü	2007	194.7	4.2		6.9
7	Áóí ááí áü	2007	58.0	1.2		2.1
Çààáí í éí ò àèááè			4 633.2	24.6	28.7	
Улсын дүнгээр			18 849.5	100.0	843.4	

Ой зохион байгуулалтын ажлын санхүүжилтийн төлөвлөлт, хянагдаж батлагдсан байдал										
№	Арга хэмжээний нэр	2007 оны			2008 оны			2009 оны		
		Хэмжээ /мян.га/	Төсөл /сая.төг/	Баталсан /сая.төг/	Хэмжээ /мян.га/	Төсөл /сая.төг/	Баталсан /сая.төг/	Хэмжээ /мян.га/	Төсөл /сая.төг/	Баталсан /сая.төг/
1	Зохион байгуулалт	1800.0	126.0	90.0	1800.0	144.0	144.0	1900.0	266.0	228.0
2	Дагалт баялгийн нөөцийн судалгаа	-	100.0	-	-	-	-	-	-	-
ДҮН			226.0	90.0	1800.0	144.0	144.0	1900.0	266.0	228.0

5.24 2008 онд Архангай, Өвөрхангай аймаг, Сэлэнгэ аймгийн 2 сумын бүгд 1800.0 мянган га талбайд 144.0 сая төгрөгийн ой зохион байгуулалтын ажил хийхээр батлагдсан байна. Гэвч орон нутагт хийсэн ой зохион байгуулалтын ажлын үр дүн харагдахгүй байна.

- 2008 онд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 248.8 мянган га, Хүдэр сумын 172.4 мянган га талбайд “Хөвчийн хоймор” ХХК-ийн хийсэн ой зохион байгуулалтын ажлын тайлан, техникийн тодорхойлолт, стандарт шаардлагыг хангаагүйгээс эцэслэн гараагүй байна.
- 2008 íí ä Архангай аймгийн 16 ñóí ýí í é çì òèìí ààèãóóèàèòùí àæùã Í УХСТ-өөр òèèèýí Í éí áàçäàä äáò èóóèçáí гэх боловч тус аймагт тайлан ирээгүй байна.

5.25 Хуулийн 7.4.1-т зааснаар ойн сангийн нөөцийг тогтоох, бүс нутгийн хөгжлийн төлвийг тодорхойлохтой холбогдсон хамгаалалтын болон ашиглалтын бүсийн ойд ой зохион байгуулалт хийх зардлыг төлөвлөж ирсэн ч улсын менежментийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад шаардагдах зардлыг төлөвлөж байгаагүй байна. Харин энэхүү ажлыг 2010 онд хийж гүйцэтгэхээр 30.0 сая төгрөгийг төлөвлөжээ.

Нөхөрлөлийн гэрээгээр эзэмших ойн санд хийх ой зохион байгуулалтын хөрөнгийг төсөвт тусгаагүй байна

5.26 Хуулийн 7.4.2-т “хамгаалалтын бүс тогтоох болон ашиглалтын бүсийн ойд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр ой зохион байгуулалт хийх, менежментийн төлөвлөгөөг боловсруулахад шаардагдах зардлыг орон нутгийн төсвөөс” санхүүжүүлэхээр заасан боловч хөрөнгө төлөвлөж байгаагүй байна.

5.27 Хуулийн дагуу 7.4.3-д зааснаар⁹ и^o о^o д^o ө^o ө, àæ àóóéí íúææ áàéäóóëèàãí эзэмшиж ашиглаж байгаа ойд хийх ой зохион байгуулалт, менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг тэдний хөрөнгөөр санхүүжүүлсэн, энэхүү ажлыг хэрэгжүүлж ирсэн талаар ямар нэг судалгаа, мэдээ болон тайлагнасан зүйл Ойн газарт алга байна.

5.28 Мөн хуулийн заалтын дагуу¹⁰ улсын төсвөөс санхүүжүүлэх анх удаа нөхөрлөлийн эзэмшилд олгогдож байгаа ойн сангийн тодорхой хэсэгт хийх ойн зохион байгуулалтын ажилд шаардагдах хөрөнгийг төлөвлөөгүй байна.

5.29 2008 онд ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний хөрөнгийн эх үүсвэрээс Хөвсгөл аймгийн 12 нөхөрлөлийн 33703 га, Хэнтий аймгийн 11 нөхөрлөлийн 34091 га, Булган аймгийн 13 нөхөрлөлийн 7166 га, Төв аймгийн 15 нөхөрлөлийн 34532 га, нийт 109.5 мянган га талбайд ой зохион байгуулалтын ажлыг бүгд 21.8 сая төгрөгөөр “ОХСТ” ХХК гүйцэтгэн 2009 оны 7 дугаар сард хүлээлгэн өгчээ.

5.30 Ой зохион байгуулалтын хээрийн хайгуул судалгааны ажил бүрэн хийгдсэн боловч Булган аймгийн Хангал, Бугат сум нөхөрлөлд эзэмшүүлсэн ойн хилийн цэсийг тогтоосон ИТХ-ын тогтоол гараагүй, Төв аймгийн Жаргалант сумын 2 нөхөрлөлийн эзэмшлийн ойн хилийн цэс бүрэн тогтоогдоогүйгээс ажлын гүйцэтгэл бүрэн гараагүй байна.

5.31 БОАЖС-ын 2009 оны 15 дугаар тушаалаар “Анх удаа ойн санг гэрээгээр эзэмшиж буй ойн нөхөрлөлийн ойн санд ой зохион байгуулалтын ажил гүйцэтгэх”-д Сэлэнгэ аймагт шинээр байгуулагдсан нөхөрлөлийн 174.6 мянган га талбайд ой зохион байгуулалтын зардалд 20952.0 мянган төгрөг баталжээ. Гэтэл Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2009 онд ойн зохион байгуулалт хийхээр төлөвлөгдсөн байгаа тул энэхүү ажлын хүрээнд анх удаа нөхөрлөлийн эзэмшилд олгогдож буй ойн сангийн хэсгийг хамруулах боломжтой.

⁹ 7.4.3.гэрээний дагуу нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа ойд хийх ой зохион байгуулалт, менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг тэдгээрийн хөрөнгөөр,

¹⁰ “...харин анх удаа нөхөрлөлийн эзэмшилд олгогдож байгаа ойн сангийн тодорхой хэсэгт хийх ой зохион байгуулалтыг улсын төсвийн хөрөнгөөр”

5.32 Ойн газраас энэхүү асуудлыг харгалзан шинээр байгуулагдсан Булган аймгийн 15 нөхөрлөлийн 77049 га, Хөвсгөл аймгийн 31 нөхөрлөлийн 99820 га, Увс аймгийн 5 нөхөрлөлийн 12023 га, бүгд 41 нөхөрлөлийн 188.9 мянган га талбайд ой зохион байгуулалт хийлгэхээр “Ойн хайгуул” ХХК-ийг шалгаруулжээ.

Үнэт цаасны төлөвлөлт бодитой хийгдэхгүй, бүртгэл тооцоо хангалтгүй, хүчингүй болгосон үнэт цаасны тооцоог бүрэн хийгээгүй байна

5.33 Хуулийн 31.4-т заасны дагуу мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээ, ойгоос хэрэглээний болон түлээний мод бэлтгэх, тээвэрлэх эрхийн бичиг гэсэн үнэт цаасыг ашиглаж байна. БОАЖС-ын 2009 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 128 дугаар тушаалаар¹¹ үнэт цаасны загварыг батлан, 2009 оны 7 дугаар сарын 1-нээс мөрдүүлжээ.

5.34 Ойн газрын даргын 2009 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 73 дугаар тушаалаар хуучин ашиглаж байсан үнэт цаасыг устгах, шинээр хэвлүүлэх ажлыг зохион байгуулсан боловч хүчингүй болсон үнэт цаасны тооцоо хийгдээгүй байна.

5.35 Гарал үүслийн гэрчилгээ, эрхийн бичгийг “Мигма”, “Жиком пресс” ХХК-тай гэрээ байгуулан 64715 ширхгийг 24.7 сая төгрөгөөр хэвлүүлж, захиалга ирүүлсэн Архангай, Булган, Дархан-Уул, Завхан, Төв, Увс, Хөвсгөл, Хэнтий зэрэг 9 аймагт 58767 ширхэг буюу 20.7 сая төгрөгийн үнэт цаасыг шинээр олгож, одоогийн байдлаар 5948 ширхэг буюу 4.0 сая төгрөгийн үнэт цаас үлдэгдэлтэй байна.

5.36 2009 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар хүчингүй болсон гарал үүслийн гэрчилгээ 4899 ширхэг, бусад эрхийн гэрчилгээ 36038 ширхэг, нийт 37.8 сая төгрөгийн үнэт цаасыг буцаан татаж тооцоо хийсэн боловч Завхан, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий аймагтай 6.5 сая төгрөгийн гарал үүсэл, бусад эрхийн гэрчилгээний тооцоо хийгдээгүй байна.

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Ерөө, Мандал сумдад гарал үүслийн болон бусад эрхийн бичгийн үлдэгдлийн тооцоог 2009 оны 9 дүгээр сарын 16, 20-ны байдлаар хийв.

- Сэлэнгэ аймгийн БОАЖГ 2007-2008 он, 2009 оны эхний хагас жилийн байдлаар үнэт цаасны орлогын 1508.4 мянган төгрөгийг аж ахуйн үйл ажиллагаанд зарцуулсныг Ойн газарт төвлөрүүлэх шаардлагатай гэж үзэв.

- Сэлэнгэ аймгийн ИТХ 2008 оны 7 дугаар тогтоолоор УБТЗ-ын Мандал сум дахь МБУ-т 6000 м³ мод бэлтгэх хуваарь баталсан атал 1648 м³-ээр илүү бэлтгэсэн байна.

- Мөн Ерөө сумын Засаг дарга С.Ганболдын цохолтоор хуваариас гадна 1500 м³ мод бэлтгэжээ.

- Алтанбулаг суманд тооцоо хийгээгүй байсан хэрэглээний 30 м³ хүртлэх модны эрхийн бичиг 33 ширхэг, Мандал сумаас хэрэглээний 10 м³ модны эрхийн бичиг 16 ширхэг, 10-60 м³ модны гарал үүслийн 9 ширхэг гэрчилгээ, бүгд 58 ширхгийг аймгийн БОАЖГ-т хүргүүлэв.

Ойн санг хамгаалах, зохистой ашиглах, төмөр замын дэр модны хэрэгцээг багасгах зорилгоор 1997 онд Сэлэнгэ аймгийн Хөтөл тосгонд байгуулсан үйлдвэр жилд 216.0 мянган ширхэг бетонон дэр үйлдвэрлэх хүчин чадалтай ч бүрэн хүчин чадлаараа ажилладаггүй байна.

“УБТЗ” ХНН нь 1952 оноос 29.0 мянган га талбай ойн санг хугацаагүйгээр эзэмшиж байгаа бөгөөд МБУ 2009 онд Сэлэнгэ аймгийн Мандал, Ерөө, Булган аймгийн Сэлэнгэ сумын нутгаас 25.8 мянган м³ мод бэлтгэх төлөвлөгөөтэй боловч зохих зөвшөөрөл, шийдвэргүйгээр Булган аймагт 8220.4 м³, Сэлэнгэ аймагт 1648 м³ мод илүү бэлтгээд байна.

¹¹ 31.5. Энэ хуулийн 31.4-т заасан гарал үүслийн гэрчилгээний загвар, түүнийг олгох журмыг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засагийн газрын гишүүн батална.

᠔ᠦᠳᠦᠶᠡᠭᠦᠰᠡᠢᠶᠡ, 1460 ᠊³ түлээ бэлтгэхээр гэрээ байгуулан үнэт цаасыг шууд олгосон мөртлөө бэлтгэлийн явц, гүйцэтгэлд хяналт тавьж гэрээг дүгнээгүй байна.

Орхон аймгийн Жаргалант суманд 2008 онд 3000 м³ мод бэлтгэх зөвшөөрөл олгогдсон байтал 3426 м³ мод бэлтгэх эрхийн бичиг олгожээ. Мөн аеі аеіі і оо аа аүаһауᠳᠦᠳᠦ ааі аеі о ууауᠳᠡᠭᠡᠶᠡᠭᠡ аоё і іä і іäі і äᠵᠡ ууауᠳᠡᠭᠡᠶᠡ а гарал үүслийн гэрчилгээг БОАЖГазрын дарга Х.Машбат олгож байжээ. □л □-□□ 193-200, 234-250 □□□□ □□□□ □□□□ 25 □□□□□□□□ □□□□ □□□□□□□□ □□□□□ 183 □□□□□ □□□□□ □□□□ 1 □□□□□□□□□□ □□□□□ □□□□□

Төв аймгийн Мөнгөнморьт сумын байгаль хамгаалагч н.Намсрай 2 ширхэг 60 м3 мод бэлтгэх эрхийн бичиг дутагдуулсан тул 672.0 мянган төгрөгийн төлбөрийн акт бичигджээ.

Ойн нөөц болон дагалт нөөц ашиглах төлбөр хураамжийг бүрэн тооцохгүй, орлогыг зориулалт бусаар зарцуулж байна

5.37 2006-2008 оны байдлаар ойгоос бэлтгэсэн модны 84.8-91.0 хувийг ахуйн болон түлээний зориулалтаар бэлтгэсэн мод эзэлж байна.¹²

5.38 Ойгоос мод бэлтгэх дээд хэмжээг БОАЖС-ын тушаалаар жил бүр тогтоож байна. 2009 онд 1428.2 мянган м³ мод бэлтгэхээр төлөвлөгдсөн нь 2007 оноос 2.3 дахин, 2008 оныхоос 1.9 дахин нэмэгдсэн байна.

№	Үзүүлэлт	Хэмжих Нэгж	2006 он	2007 он	2008 он	2009 оны Төлөвлөгөө
1	Ойгоос мод бэлтгэх дээд хэмжээ	/мян.м3/	599.0	626.0	750.0	1 428.2
2	Ойгоос бэлтгэсэн нийт модны хэмжээ	/мян.м3/	574.8	580.5	649.5	1 428.2
	Үүнээс: Хэрэглээний мод	/мян.м3/	54.2	52.5	98.6	195.6
	Түлээ бэлтгэх	/мян.м3/	520.7	528.0	550.9	1 232.6
3	Төвлөрүүлсэн орлогын хэмжээ	/сая.төг/	1 054.9	1 321.1	1 530.5	2 058.5
4	Төвлөрүүлсэн хөрөнгийн 1м3-т ногдох төлбөрийн хэмжээ (3/2)	/төг/	1 835	2 275	2 356	1 441

5.39 Гэтэл ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрт 2009 онд 2058.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөсөн нь 2007 онд төвлөрүүлсэн орлогоос 1.5 дахин, 2008 оныхоос 1.3 дахин нэмэгдэж байгаа нь бэлтгэх модны өсөлттэй харьцуулахад бага байна. Өөрөөр хэлбэл 2009 онд мод бэлтгэлийн ажиллагаанаас олох орлогын хэмжээ нь 2006 онд бэлтгэсэн 1 м³-т ногдох төлбөрийн хэмжээнээс бага байна.

5.40 Мод бэлтгэх хэмжээг орон нутагт хүргүүлж байгаа ч ᠔᠔᠗᠗᠗᠗᠔᠔᠑᠑ дагуу аеі аеіі È᠒᠒-аас тогтоол гаргаагүй, хуваарийг ᠔ᠦᠳᠦᠭᠡᠶᠡᠭᠡ, батлагдсан хэмжээнд мод аүᠡᠳᠡᠭᠡᠶᠡᠭᠡ боловч ойн нөөцийг ашигласны орлогын төлөвлөгөө давж биелж байсан нь ойгоос бэлтгэх модны хэмжээ, оён нөөц болон дагалт нөөц ашигласнаас олох орлогын ᠔᠔᠗᠗᠗᠗᠗᠗ бодитой бус, мод бэлтгэх шийдвэр нь захиалга, бодит судалгаанд үндэслэгдээгүй, хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

БОС-ын 2007 оны 12 дугаар сарын 18-і ү ᠔᠗᠔᠔᠔᠔ 367 дугаар тушаалаар “2008 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг” баталсан бөгөөд Архангай аймагт 100.0 мянган м³ хэрэглээний болон түлээний мод бэлтгэх шийдвэр гаргаснаас аймгийн ИТХ-ын 2007 оны 12 дугаар сарын 21-ний 8 дугаар тогтоолоор хэрэглээний болон түлээний модны дээд хязгаарыг 88.1 мянган ᠊³ хэмжээгээр тогтоож, үүнээс 59.7 мянган м³ мод бэлтгэж 67.5 хувееі аеаеуᠡᠳᠡ о үе аае᠔᠗᠗ тухайн онд ойн нөөцийг ашиглуулснаас олох і ᠔᠔᠗᠗᠗᠗ ᠔᠔᠗᠗᠗᠗᠗ 15337.1 і үі ааі ᠔᠔᠗᠗᠗᠗᠗᠗ аорó 112.5 хувиар ааааеаеаеіүйі байна.

¹² Эх үүсвэр: Ойн газар, орон нутгаас авсан мэдээнд суурилав.

- 2009 $i i \dot{u}$ $\dot{y}o\dot{i}$ $e\acute{e}$ 9 $\dot{n}a\dot{d}\dot{u}\dot{i}$ $\acute{a}\acute{a}\acute{e}\acute{a}\acute{e}\acute{a}\acute{a}\acute{d}$ \dot{i} $\acute{e}\acute{a}\dot{i}$ \dot{i} \dot{n} 82.6 мянган i^3 мод бэлтгэхээс 38.9 i^3 \dot{i} \dot{i} \acute{a} бэлтгэж 47.1 хувийн $\acute{a}\dot{z}\acute{o}\dot{y}\acute{o}$ $\acute{a}\dot{y}\acute{o}$ $\acute{y}\acute{e}$ $\acute{a}\acute{a}\acute{e}\acute{o}\acute{a}\acute{a}$ \dot{i} $\acute{d}\acute{e}\dot{i}$ $\acute{a}\dot{u}\dot{i}$ \acute{o} $^\circ\acute{e}^\circ\acute{a}\acute{e}^\circ\acute{a}^\circ$ 78.5 хувийн биелэлттэй $\acute{a}\acute{a}\acute{e}\dot{i}$ \acute{a} .
- 2008, 2009 $i i \dot{u}$ $\dot{y}o\dot{i}$ $e\acute{e}$ 9 $\dot{n}a\dot{d}\dot{u}\dot{i}$ $\acute{a}\acute{a}\acute{e}\acute{a}\acute{e}\acute{a}\acute{a}\acute{d}$ $\acute{o}\dot{y}\acute{d}\acute{y}\acute{a}\acute{e}\dot{y}\dot{y}\dot{i}$ $\acute{e}\acute{e}$ \dot{i} \dot{i} $\acute{a}\dot{i}$ \dot{u} $\acute{a}\acute{a}\acute{o}$ $\acute{e}\acute{a}\acute{a}\acute{n}\acute{a}\dot{i}$ $\acute{o}\dot{y}\dot{i}$ $\acute{a}\dot{y}\dot{y}\acute{a}$ $\acute{E}\acute{o}$ $\acute{a}\dot{i}$ $\acute{e}\acute{d}$, $\acute{O}\dot{y}\dot{i}$ $\acute{o}\dot{y}\acute{d}$, $\acute{O}\acute{a}\acute{e}\acute{d}\acute{o}\acute{a}\dot{i}$, $\acute{Y}\acute{d}\acute{a}\dot{y}\dot{i}$ $\acute{y}\dot{i}$ $\acute{a}\dot{i}$ $\acute{a}\acute{a}\acute{e}$ $\dot{n}\acute{o}\dot{i}$ \acute{a} $\acute{o}\dot{y}\acute{o}$ $\acute{d}\dot{z}\acute{z}\acute{e}\dot{y}\dot{i}$ $\acute{o}\dot{y}\acute{d}\acute{y}\acute{a}\acute{e}\dot{y}\dot{y}\dot{i}$, мод бэлтгээсэн тухай мэдээ гараагүй атал $\acute{A}\acute{o}\acute{e}\acute{a}\acute{a}\dot{i}$ $\dot{n}\acute{o}\dot{i}$ $\acute{a}\dot{i}$ \acute{a} 10031.5 \dot{i} $\dot{y}\dot{i}$ $\acute{a}\acute{a}\dot{i}$ \acute{o} $^\circ\acute{a}\acute{d}^\circ\acute{a}\acute{e}\acute{e}\dot{i}$ \dot{i} $\acute{d}\acute{e}\dot{i}$ $\acute{a}\dot{u}\dot{i}$ \acute{o} $^\circ\acute{a}\acute{e}^\circ\acute{d}\dot{z}\acute{z}\acute{e}\dot{n}\dot{y}\dot{i}$, $\acute{O}\acute{a}\acute{e}\acute{d}$ $\dot{n}\acute{o}\dot{i}$ $\acute{a}\dot{i}$ \acute{a} \acute{o} $\dot{z}\acute{e}\dot{y}\dot{y}\dot{i}$ $\acute{e}\acute{e}$ мод бэлтгэх $\acute{o}\dot{y}\dot{i}$ $\acute{a}\dot{y}\dot{y}\acute{a}$ $\acute{o}\dot{y}\acute{o}$ $\acute{d}\dot{z}\acute{z}\acute{e}\acute{n}$ \dot{i} $\acute{e}\dot{i}$ \dot{i} $\acute{d}\acute{e}\dot{i}$ $\acute{a}\dot{u}\dot{i}$ \acute{o} $^\circ\acute{e}^\circ\acute{a}\acute{e}^\circ\acute{a}^\circ$ \acute{a} 545.6 \dot{i} $\dot{y}\dot{i}$ $\acute{a}\acute{a}\dot{i}$ \acute{o} $^\circ\acute{a}\acute{d}^\circ\acute{a}^\circ\acute{d}$ $\acute{a}\acute{a}\acute{a}\acute{o}\acute{o}\acute{e}\acute{a}\dot{i}$ $\acute{a}\acute{e}\acute{a}\acute{e}\dot{z}\acute{z}\acute{e}\dot{n}\dot{y}\dot{i}$ $\acute{a}\dot{y}\dot{y}\dot{i}$ $\dot{n}\acute{o}$ $\acute{a}\acute{o}$ $\acute{e}\dot{n}\acute{o}$ $\acute{e}\acute{e}$ \dot{i} $\acute{y}\acute{a}\dot{y}\dot{y}$ $\acute{a}\acute{a}\acute{d}\dot{n}\acute{a}\dot{i}$ $\acute{a}\acute{a}\acute{e}\dot{i}$ \acute{a} .
- Тус аймаг 1 m^3 хэрэглээний модыг 6700 төгрөгөөр, түлээний модыг 1100 төгрөгөөр тооцож төлөвлөдөг атал бодит байдалд 1 m^3 хэрэглээний модыг 8150 төгрөгөөр, түлээний модыг 2200 төгрөгөөр тооцон эрхийн бичиг бичиж орлогын төлөвлөгөөг биелүүлсэн байна.
- БОАЖС-ын 2009 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 27 дугаар тушаалаар баталсан хуваариас аймгийн ИТХ сумдад хуваарилсан тогтоол гаргаагүй байна.

Хөвсгөл аймгийн хэмжээгээр ойн нөөц болон дагалт нөөцийг ашиглах төлбөр хураамжийн төвлөрүүлэлтэд тавих хяналт байхгүй, эрхийн бичгийн зарлага гараагүй атлаа бэлэн мөнгөний орлогын баримтаар орлого төвлөрүүлж байжээ. Мөн аймагт түүвэрлэх болон арчилгааны огтлолтоор 20.0 мянган m^3 хэрэглээний, 98.2 мянган m^3 түлээний модны эрхийг тодорхой бус шалтгаанаар хуваарилаагүй үлдээсэн байна.

Сэлэнгэ аймгийн Ерөө суманд ойн нөөц болон дагалт нөөцийг ашигласны төлбөрийн орлогоос сумын төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны хувьсах болон тогтмол зардлыг санхүүжүүлж байсан бөгөөд мөн аймгийн Мандал сумаас “Байгаль орчныг хамгаалах сан”-д /БОХС/ төвлөрүүлэх орлогыг хуулийн дагуу зарцуулалгүй¹³ өөр салбарт ажиллаж буй ажилтны цалин, түлш халаалт, гэрэл цахилгаан, шуудан холбоо, томилолтын зардал зэрэгт нийт 9254.6 мянган төгрөг зарцуулсан байна.

Дархан-Уул аймагт энэхүү орлогоос зориулалт бусаар зарцуулсан, эрхийн бичгийн болон хууль бусаар бэлтгэсэн модны орлого төсөвт төвлөрүүлээгүй зэрэг зөрчилд 2536.2 мянган төгрөгийн төлбөрийн акт бичигджээ.

Орхон аймгийн Жаргалант суманд 2008 онд 3000 i^3 \dot{i} \dot{i} \acute{a} $\acute{a}\dot{y}\acute{o}$ $\acute{a}\dot{y}\acute{o}$ $\acute{z}^\circ\acute{a}\dot{a}$ $^\circ\circ\acute{d}^\circ\acute{e}$ \dot{i} $\acute{e}\acute{a}\dot{i}$ $\acute{a}\acute{a}\dot{n}\dot{i}$ \dot{i} $\acute{a}\acute{a}\acute{e}\acute{o}$ $\acute{a}\acute{e}$ 3426 i^3 \dot{i} \dot{i} \acute{a} $\acute{a}\dot{y}\acute{o}$ $\acute{a}\dot{y}\acute{o}$ $\acute{y}\acute{d}\acute{o}\acute{e}\acute{e}\dot{i}$ $\acute{a}\acute{e}$ - $\acute{e}\acute{a}$ \dot{i} $\acute{e}\acute{a}\dot{i}$ $\dot{n}\dot{i}$ \dot{i} , 2009 $i i \dot{a}$ $\acute{z}^\circ\acute{a}\dot{a}$ $^\circ\circ\acute{d}^\circ\acute{e}\acute{a}\acute{z}\acute{e}$ $\acute{a}\acute{a}\acute{e}\acute{o}\acute{a}\acute{a}$ Засаг дарга Б.Пүрэвээ

КАССЫН ОРЛОГЫН БАРИМТ № 2009101632515 - 0			
Банк хоорондын гүйлгээ			
Дебит	Ж САНЖАРГАЛ		
	ВА Балэн	2009.10.18	
	902518 - Т сан Ор Жаргалант ТТ - Төрийн сан	35,200.00	MNT
Кредит	ОН ТӨСӨВ		
	210200995	35,200.00	MNT

мод бэлтгэх эрхийн бичиггүйгээр зөвхөн банкинд тушаасан төлбөрийн баримтын ард хаанаас, хэдэн m^3 бэлтгэхийг зөвшөөрсөн цохолт хийн 525 i^3 \dot{i} \dot{i} \acute{a} $\acute{o}\acute{o}\acute{o}\acute{y}\dot{i}$ $\acute{a}\acute{o}\dot{n}\acute{a}\dot{a}\dot{r}$ $\acute{a}\dot{y}\acute{o}$ $\acute{a}\dot{y}\acute{y}\acute{l}\acute{s}\acute{e}\dot{n}$ байна. Илүү болон зөвшөөрөлгүй бэлтгэсэн $\acute{z}^\circ\acute{d}$ - $\acute{e}\acute{e}\acute{a}$ $\acute{y}\acute{e}\dot{i}$ $\acute{e}\dot{i}$ $\acute{a}\acute{e}$ $\acute{y}\acute{a}\acute{e}\acute{e}\dot{i}$ $\acute{z}\dot{i}$ $\acute{y}\acute{e}\acute{a}\dot{y}\acute{y}\acute{a}\dot{y}\acute{y}\dot{y}\acute{d}$ бүгд 9129.6 \dot{i} $\dot{y}\dot{i}$ $\acute{a}\acute{a}\dot{i}$ төгрөгийн нөхөн төлбөр тооцон төлбөрийн акт бичиж танилцуулсан боловч зөвшөөрөөгүй тул хуулийн байгууллагад шалгуулахаар шилжүүлээд байна.

- Хууль бус шийдвэр гаргасан сумын Засаг дарга дараахь тайлбарыг өгсөн байна. Үүнд:
1. “2009 $i i \dot{u}$ 8 $\dot{n}a\dot{d}\dot{a}$ модны хулгай дээд цэгтээ хүрч $\acute{a}\acute{a}\acute{e}\dot{n}\acute{a}\dot{i}$ тул $\acute{o}\acute{o}\acute{e}\acute{a}\acute{e}\acute{a}\acute{a}\acute{d}$ \dot{i} \dot{i} \dot{i} \acute{a} $\acute{a}\acute{o}$ $\acute{e}\acute{o}\acute{o}\acute{e}\acute{a}\acute{a}\acute{e}\acute{a}\acute{d}$ \acute{o} $^\circ\acute{e}\acute{a}^\circ\acute{d}\acute{e}\acute{e}\acute{a}$ $\acute{a}\acute{a}\acute{a}\acute{a}$ $\acute{z}^\circ\acute{a}\dot{a}$ $^\circ\circ\acute{d}^\circ\acute{e}$ $^\circ\acute{a}^\circ\acute{o}$ $\acute{o}\dot{y}\acute{d}\acute{y}\acute{a}\acute{o}$ $\acute{y}\acute{e}$ $\acute{a}\acute{a}\acute{e}\dot{n}\acute{a}\dot{i}$,
 2. $\acute{O}\acute{o}\acute{o}\acute{d}\acute{a}\acute{e}$ \dot{i} \dot{i} \acute{a} $\acute{o}\dot{i}$ $\acute{a}\acute{a}\acute{a}\acute{o}\acute{a}\acute{a}$ $\acute{y}\acute{e}\dot{i}$ $\acute{e}\dot{i}$ $\acute{a}\acute{e}\acute{o}$ $\dot{y}\dot{i}$ $\acute{a}\acute{d}$ \dot{i} $\acute{y}\acute{a}\dot{y}\dot{i}$ $\acute{o}\dot{i}$ \acute{d} $\acute{a}\acute{a}\acute{e}\acute{o}\acute{a}\acute{z}\acute{e}$,
 3. $\acute{A}\dot{i}$ $\acute{A}\acute{E}\acute{A}$ - $\dot{u}\dot{i}$ $\acute{a}\acute{a}\acute{d}\acute{a}\acute{a}\acute{o}$ $\acute{a}\acute{e}$ $\acute{y}\acute{d}\dot{u}\acute{a}\acute{z}^\circ\acute{a}\dot{a}$ $^\circ\circ\acute{d}^\circ\acute{e}$ $\acute{a}\acute{a}\dot{n}\acute{a}\dot{i}$, \acute{o} $^\circ\acute{d}\acute{e}\acute{e}\dot{i}$ $\acute{a}\acute{a}\acute{e}\acute{a}\acute{o}\acute{o}\acute{e}\acute{e}\acute{a}\acute{a}\dot{u}\dot{i}$ $\acute{o}\dot{z}\dot{i}$ \acute{a} $\dot{n}\acute{o}\acute{d}\acute{o}$ $\acute{e}\acute{a}\acute{a}\dot{n}$ $\acute{a}\dot{i}$ $\acute{e}\acute{a}\acute{e}$ $\acute{e}\acute{d}\acute{a}\dot{y}\acute{a}$ \dot{i} \dot{i} $\acute{a}\acute{a}\acute{z}\acute{e}$ $\acute{a}\acute{a}\acute{e}\acute{o}$, $\dot{n}\acute{a}\acute{z}\acute{e}$, $\acute{A}\dot{i}$ $\acute{A}\acute{E}\acute{A}$ - $\dot{u}\dot{i}$ $\acute{a}\acute{o}\acute{d}\acute{o}\acute{o}\acute{a}\acute{a}\acute{a}\dot{n}\dot{i}$ \dot{i} $\acute{a}\dot{i}$ \dot{i} $\acute{a}\dot{y}\acute{o}$ $\acute{a}\dot{y}\acute{y}\acute{e}$ $\acute{a}\acute{a}\acute{a}\acute{o}\acute{a}\acute{z}\acute{e}$ $\acute{a}\acute{a}\acute{e}\dot{i}$ \acute{a} .
 4. \dot{i} $\acute{e}\dot{i}$ \acute{o} $\acute{o}\acute{o}\acute{a}\acute{e}$ $\acute{o}\acute{o}\acute{o}\acute{y}\dot{i}$ \acute{o} \dot{i} $\acute{a}\acute{o}$ \dot{i} \dot{i} $\acute{a}\dot{i}$ \dot{u} $\acute{o}\dot{y}\acute{d}\acute{y}\acute{a}\acute{e}\acute{o}\acute{a}\acute{z}\acute{e}$, \acute{o} $\acute{o}\acute{d}\acute{o}$ $\acute{e}\acute{e}\acute{o}$ $\dot{u}\dot{i}$ $\acute{a}\acute{o}\acute{d}\dot{i}$ $\acute{a}\acute{a}\acute{d}$ $\acute{y}\acute{a}\acute{e}$ $\acute{a}\acute{a}\acute{e}\acute{a}\acute{a}\acute{a}$, $\acute{o}\acute{o}\acute{o}\acute{e}\acute{e}\acute{e}\acute{a}$ $\acute{o}\dot{y}\acute{d}\acute{y}\acute{a}\acute{e}\acute{z}\acute{e}\acute{a}\dot{i}$ $\acute{e}\dot{i}$ $\acute{o}\acute{a}\acute{z}\acute{e}$ $\acute{a}\acute{a}\acute{e}\dot{i}$ \acute{a} ” гэсэн тайлбарыг өгсөн байна.
- Мөн $\dot{n}\acute{o}\dot{i}$ анд \acute{o} $\dot{z}\acute{e}\dot{y}\dot{y}\dot{i}$ $\acute{e}\acute{e}$ \dot{i} \dot{i} $\acute{a}\dot{i}$ \dot{u} $\acute{z}\dot{i}$ $\acute{d}\acute{e}\acute{o}\acute{e}\acute{a}\acute{e}\acute{o}$ $\acute{a}\acute{a}\acute{d}$ $\acute{o}\dot{i}$ $\acute{a}\dot{i}$ $\acute{a}\acute{e}$, $\acute{o}\acute{o}\acute{o}\acute{d}\acute{a}\acute{e}$ $\acute{a}\acute{e}\acute{o}$ $\dot{z}\dot{z}$ \acute{o} $\dot{z}\dot{z}\acute{o}$ $\acute{z}^\circ\acute{a}\dot{a}$ $^\circ\circ\acute{d}\acute{e}\acute{e}\acute{a}$ \dot{i} $\acute{e}\acute{a}\dot{i}$ $\acute{a}\acute{e}$ байгаа гэх $\acute{a}\dot{i}$ $\acute{e}\dot{i}$ \acute{a} - \dot{i} \dot{i} \dot{i} $\acute{a}\dot{y}\acute{o}$ $\acute{a}\dot{y}\acute{y}\acute{e}$ $\acute{a}\acute{a}\acute{e}\acute{a}\acute{a}$ $\acute{a}\acute{a}\acute{z}\acute{a}\acute{d}$ $\acute{a}\dot{y}\acute{y}\acute{d}$ \dot{i} \dot{u} \dot{i} \dot{i} $\acute{e}\acute{e}$ $\dot{z}\dot{z}\acute{y}\acute{o}\acute{y}\acute{a}$ \dot{i} $\acute{e}\acute{o}$ \dot{i} \dot{i} \dot{i} \dot{i} \acute{a} $\acute{a}\dot{y}\acute{o}$ $\acute{a}\dot{y}\acute{y}\acute{e}$ $\acute{a}\acute{a}\acute{e}\acute{s}\acute{a}\dot{n}$

¹³ “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээний тухай хууль”

ба мод бэлтгэх талбайг тусгаарлаагүйгээс тус сумын Байгаль орчны улсын байцаагч М.Гантөмөр дур мэдэн мод бэлтгэх талбай зааж өгч байжээ.

- Дагалт нөөц ашигласны төлбөр хураамжаар дутуу төвлөрүүлсэн 1529.5 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт бичжээ.

Хуулийн дагуу ойн санг гэрээгээр эзэмшүүлэх ажил хийгдэхгүй байгаагаас хууль бусаар мод бэлтгэх ажиллагааг зогсоож чадахгүй байна

5.41 2009 î î ù 11 дүгээр ñàðîí 12-ны áàéäèààð Õàããààæéí õýðýá á¿ðòäýõ äãçàð, áóñàä õýí àèð ø àèããèòîí áàéãòèèäãòäèè òàì òðàì òóóèü áóñààð î î ä áýèðäýí õóãàãäæ 145-ù äèèð¿¿ñíí ýýñ 1412.5 î³ мод хураагдаж 44.8 сая төгрөгийн экологи эдийн засгийн үнэлгээ хийгдсэн байна. Үүнээс 108.0 мянган төгрөгөөс дээш õì òèðì è ó-ðóóèæýð¿¿гийн хэрэг үүсгэгдэн î ðì èòðì ðò ø èèæýíí õýðýá81 áàéí à.

5.42 Хууль бусаар бэлтгэсэн модны хэмжээг модны төрөл, экологи эдийн засгийн үнэлгээ, мод бэлтгэсэн газрын хилийн зааг мужаар үзүүлбэл:

Хууль бусаар бэлтгэсэн модны			Хууль бусаар мод бэлтгэсэн газар нутаг /хувиар/			
Төрөл	Хэмжээ /хувиар/	Экологи, эдийн засгийн үнэлгээ /хувиар/	1-р муж /Улсын ойн сангийн онцгой, хамгаалалтын бүсийн бүх ой, Нийслэлийн ногоон бүс, ДЦГ, ТХГ/	2-р муж /Улсын ойн сангийн ашиглалтын бүсэд багтах Дорнод, Өвөрхангай, Увс аймгийн ойн нөөц/	3-р муж /Архангай, Булган, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Хэнтий аймгийн нутгийн ой сан/	4-р муж /Улсын ойн сангийн ашиглалтын бүсэд багтах Хөвсгөл, Хэнтий аймгийн ойн нөөц/
Нарс	56.1	27.7	17.0	1.2	79.2	2.4
Шинэс	32.2	63.2				
Хбө	11.6	8.9				

5.43 Хүснэгтээс үзэхэд хууль бусаар мод бэлтгэж байгаа модны 56.1 хувийг нарс эзэлж байгаа бөгөөд нийт зөрчлийн 79.2 хувь 3-р мужаас буюу Архангай, Булган, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Хэнтий аймагт гарсан байна. Мөн Нийслэлийн ногоон бүс болох Дархан цаазтай газруудад хууль бусаар мод бэлтгэх зөрчил 17.0 хувийг эзэлж байна.



Улсын хэмжээнд модны үрийн нөөц үндсэндээ алга байна

5.44 БОАЖС-ын 2008 оны 86 дугаар тушаалаар 2009 онд улсын үрийн нөөцийн санд үр худалдан авах хөрөнгө оруулалтын ажлын зардалд нийт 315 кг үрийг 62.4 сая төгрөгөөр тооцож төсөвлөсөн байна.

5.45 Үр импортлох боломж хомс, бэлтгэсэн үрийн ургалт муу, үр нийлүүлэх ажлын тендер зарлагдаагүй буюу батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах зохион байгуулалттай ажил хийгдээгүйгээс улсын үрийн нөөцийн санд үр худалдан авах ажил зогсонги байдалтай байна.

5.46 БОС-ын 2007 оны 279 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор тус яамны ТНБД-аар ажиллаж байсан Ц.Шийрэвдамба, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын “Буян-Од” ХХК-ийн захирал В.Буянтогтох нар 2007 оны 10 дугаар сарын 12-ны өдөр

“Шилмүүст модны улсын нөөцийн санг шинэчилж, үр худалдан авах гэрээ”-г байгуулж, төлбөрт 9163.0 мянган төгрөг авсан боловч нийлүүлэгч компани модны үр нийлээгүй зөрчил илэрсэн юм. Иймд “Буян-Од” ХХК-иар модны үрийн үнийг нөхөн төлүүлэх нь зүйтэй гэж үзэв.

5.47 “Буян-Од” ХХК-иас улсын нөөцийн санд авах шилмүүст модны үрийг тухайн үеийн зах зээлийн үнэ 1 кг-ыг 70.0 мянган төгрөгөөр тооцож, 130 кг үр авах ёстой байжээ. Гэтэл шилмүүст модны үрийн өнөөгийн зах зээлийн үнээр (1 кг нь 150.0 мянган төгрөг) тооцож үзвэл 19.5 сая төгрөг болж, 10.3 сая төгрөгийн алдагдал гарч байна. Гэрээнд үр нийлүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцох ямар ч заалт байхгүйгээс дээрх хохирлыг хүлээж байна.

Ойн түймрийн шалтгаан нөхцөлийг үнэн зөв тогтоох, эзэн холбогдогчид хариуцлага хүлээлгэх ажил хангалтгүй байна

5.48 Ойн газраас гаргасан мэдээгээр 2008 онд ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх болон бусад арга хэмжээнд 30.0 сая төгрөг батлагдсанаас хавар, намрын түймрийн аюултай үед телевиз, радио, сонин хэвлэлээр урьдчилан сэргийлэх сурталчилгаанд 868.0 мянган төгрөг зарцуулсан нь батлагдсан зардлын 2.9 хувийг эзэлж байна.

5.49 2009 онд ойн түймрээс урьдчилан сэргийлэх, ойн аж ахуйн бусад арга хэмжээнд 25.0 сая төгрөг батлагдсанаас гарын авлага, зурагт хуудас хэвлүүлж тараахад 2.0 сая төгрөг, хаврын түймрийн аюултай үед телевизээр ойн түймрээс урьдчилан сэргийлэх шторк цацахад 3480.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан нь дээрх зардлын 21.9 хувийг эзэлж байна.

5.50 ОБЕГ-ын мэдээгээр 2007 онд 88 сум, дүүрэгт 228 удаа түймэр гарч 512.3 мянган га ой түймэрт өртөж, түймрийг унтраахад 343.8 сая төгрөг зарцуулсан бөгөөд 195.9 тэрбум төгрөгийн экологийн хохирол учирсан бол 2008 онд 74 сум, дүүрэгт 178 удаа гал, түймэр гарч 491.6 мянган га талбай бүхий ойн түймрийг унтраахад 347.0 сая төгрөг зарцуулж, экологийн хохирол 17.1 тэрбум төгрөгт хүрчээ.

5.51 2009 оны эхний хагас жилийн байдлаар 12 аймгийн 49 суманд 98 удаа түймэр гарч 105.3 мянган га ой түймэрт өртөж, нийт 269.9 сая төгрөгийн хохирол гарсан гэх боловч энэ хохирлын хэмжээ одоо болтол бүрэн гараагүй байна.

5.52 2009 онд гарсан 58 түймрийн эзэн холбогдогч, шалтгаан тогтоогдсон бол 40 түймрийн эзэн, шалтгааныг тогтоож чадаагүй байна. Дээрх түймрийн 33 буюу 33.6 хувь Сэлэнгэ аймагт, 18 буюу 18.3 хувь Булган аймагт, 11 буюу 11.2 хувь Хөвсгөл аймагт гарчээ.

5.53 Ойн газраас 2009 оны 5 дугаар сарын 12-ны өдрөөр гаргасан мэдээгээр улсын ойн сангийн 818.3 мянган га талбай буюу 6.3 хувь шатсан байна.

Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажилд тавих хяналт сул, үр нөлөө хангалтгүй, тэмцэж буй арга оновчтой бус байна

5.54 Ойн газраас 2006-2009 оны байдлаар гаргасан судалгаагаар хөнөөлт шавж, өвчний голомттой талбай нэмэгдэж байна.

5.55 Тэмцлийн ажлыг агаарын болон газрын гэсэн ангиллын аргыг хэрэглэн 2007 онд 27.4 мянган га талбайд 225.0 сая төгрөг, 2008 онд 72.0 мянган га талбайд 700.0 сая төгрөг, 2009 онд 50.0 мянган га талбайд 685.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөн хэрэгжүүлж байна.



5.56 Ойн газраас гаргасан судалгаагаар 2007-2008 онд хийгдсэн хөнөөлт шавжтай тэмцсэн ажлын үр дүнг 85.9 хувь буюу хангалттай гэж үзжээ.

А/а	Ойг үрэг үрэгдүүлж эвчлэх үйсэлдүүлэх	Ойг үрэг үрэгдүүлж эвчлэх үйсэлдүүлэх, га		Судалгааны үр дүнг үйсэлдүүлэх, га		Ойг үрэг үрэгдүүлж эвчлэх үйсэлдүүлэх, %	
		2007	2008	2007	2008	2007	2008
1	Дельтаплан ИИД/АН-2/	11 210	-	92.0	-	88.8	-
2	Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ сум	10 700	14 234	85.6	112.4	86.6	85.4
3	Булган аймгийн Тэшиг сум	5 500	2 500	47.4	25.0	100	100
Аүн		27 410	72 020	225.0	700.0¹⁴	91.7	90.6

5.57 Гэвч тэмцлийн ажилд зориулан олгосон хөрөнгийн зарцуулалт үр ашиг, үр дүнгээ өгөөгүй гэж Булган, Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн аудитын газрууд үзсэн байна. Тухайлбал,

- Хөвсгөл аймгийн Галт, Шинэ-Идэр, Жаргалант, Төмөрбулаг сумдад тэмцлийн ажил хийгдэж 11.5 сая төгрөг, 2700 литр химийн бодис хэрэглэсэн гэх боловч нотлох зүйлгүй, ажлын баримтгүй, мэргэжлийн хяналтын болон орон нутгийн зүгээс хяналт тавьж ажиллаагүй, 2008 онд 11.8, 2009 онд 10.8 мянган га талбайд хийсэн тэмцлийн ажлын үр дүн тодорхой бус байна.
- Мөн аймгийн Төмөрбулаг сумын Засаг дарга н.Энхтуяа, Шинэ-Идэр сумын Засаг дарга Л.Өнөрсайхан нар 2008, 2009 онд гар аргаар болон үүргийн шүршигчээр хэрэгжүүлсэн ажлыг хорны чанар муугаас үр дүн багатай, устгагдаагүй гэж дүгнэжээ.
- Сэлэнгэ аймагт 2008 онд орон нутгийн төсвөөс 10.0 сая төгрөг олгосноос ОУХСТ-тэй хамтран 7 суманд судалгааны ажилд 1.5 сая төгрөг зарцуулж, хорны үнэнд 8.5 сая төгрөг шилжүүлсэн боловч устгал хийгдээгүй байна.
- Булган аймгийн Тэшиг сумын Засаг дарга С.Дорлигсүрэн 2008 онд газрын техникээр 650 га талбайд тэмцлийн ажлыг хийгээгүй гэсэн тодорхойлолтыг гаргаж өгсөн байна.

5.58 2008 онд ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажилд АН-2 онгоцоор агаараас 54.8 мянган га талбай бүхий ойд 220 цаг 21 минут хор шүршиж байсан бол 2009 оны эхний 9 сарын байдлаар 48.5 мянган га талбай бүхий ойд 158 цаг хор цацсан гэсэн Ойн газраас гаргасан тооцооноос харахад 1 цагийн нислэгээр 2008 онд 248 га, 2009

¹⁴ Гадаадын тусламж, нийслэлийн төсвөөр захиалгаар хийлгэсэн зардлыг оруулснаар тооцов.

онд 306 га ойд агаараас хор цацсан байна. Ингэж зөрүүтэй байгаа шалтгааныг 2008 онд 2-3 сумын дунд нэг хээрийн нисэх буудал сонгосон алдаатай бодлогын улмаас онгоцны нислэгийн цагийн зардал өндөр гарсан гэж Ойн газраас тайлбарлаж байна.

5.59 Ойн хөнөөлт хортон шавж их хэмжээгээр тархсан үед тэмцлийн ажилд химийн бодис хэрэглэх нь сайн үр дүн үзүүлж байгаа хэдий ч энэ бодисыг хэрэглэснээр байгальд ашигтай зарим шавж (шоргоолж) устгах, ан амьтад, самар жимс, ховор ургамал хордох зэрэг байгальд үзүүлэх хор нөлөөний талаар ямар ч судалгаа хийгдээгүй байна.

5.60 Аудитаар “Моннис эйр сервис” ХХК-ийн АН-2 онгоцоор ойн хортон шавжийг устгасан байдлыг шалгахад доорх зөрчил илрэв. Үүнд:

- ИНЕГ-ын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалт болон Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албанаас 2009 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 6/639, мөн оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 1/358 тоот албан бичгээр ирүүлсэн “Моннис эйр сервис” ХХК-ийн АН-2 онгоцны ниссэн, буусан өдөр, цаг, минутын жагсаалт тус компанийн Ойн газарт гаргаж өгсөнтэй тохирохгүй байна.
- Онгоц ниссэн баримтад (“Моннис эйр сервис” ХХК-ийн АН-2 онгоцны нислэгийн үүргийн хуудас, Ойн газраас гаргасан онгоц ниссэн өдөр бүрийн тайлан гэсэн батлагдаагүй маягт) Захиалагч, гүйцэтгэгч байгууллагын төлөөлөгчийн гарын үсэг зурагдаагүй учраас албан ёсны гэж үзэх боломжгүй байна.
- Онгоцоор ямар газар, хэдий хэмжээний талбайд хичнээн хэмжээний хор цацсан гэдгийг баталж аймаг, сумын ой хамгаалагч, ажил харууцсан засаг захиргааны ажилтан, үүрэг гүйцэтгэж байгаа болон хяналт тавьж байгаа Ойн газрын ажилтан нар гарын үсэг зурсан акт бүрэн бус бөгөөд нислэг бүрийг тодорхойлсон санхүүгийн баримт, протокол, алга байлаа.
- БОЯ, ОУХСТ болон Ойн газар 2008-2009 онд онгоцоор хортон шавжийг устгах нислэгийн тооцоог хийхдээ гэрээнийхээ дагуу төлбөр хийсэн болохоос нислэг бүрийг өдөр цаг минутаар тооцож гарын үсэг зурсан албан ёсны баримтыг үндэслээгүй байна.
- ОУХСТ, “Моннис эйр сервис” ХХК-ийн хооронд 2008 оны 7 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан нэмэлт гэрээгээр 1 цагийн хөлсийг 1.3 сая төгрөгөөр тохирсон атал Хэнтий аймгийн Дадал, Биндэр сумын нутагт 2008 оны 8 дугаар сарын 15-наас 8 дугаар сарын 27-ныг дуустал 13 хоног 28 цаг 05 минут нислэг үйлдсэн хөлсийг төлөх актанд 1 цагийн хөлсийг 1.4 сая төгрөгөөр тооцож, гэрээгээр тохирсон үнээс 2.8 сая төгрөг илүү олгосон байна.
- ИНЕГ-ын Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албанаас ирүүлсэн тодорхойлолтыг үндэслэж “Моннис Эйр сэрвис” ХХК-ийн 2009 онд хортон шавж устгах ажилд ниссэн нислэгийн цагийн тооцооноос 13 цаг 07 минутийн нислэгийн төлбөр болох 19.5 сая төгрөгийг суутган тооцох нь зүйтэй гэж үзэв.



5.61 Ойн газар “Викингийн ой” ХХК-ийн хооронд 2009 оны 7 дугаар сарын 15-ны өдөр (2009 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр дотор хийж гүйцэтгэхээр) “Булган, Сэлэнгэ аймгийн зарим сумдын нутагт өсвөр шилмүүст модны хөнөөлт шавжийн тархалт, хөнөөлийн голомт, тэдгээртэй тэмцэх ажлын гэрээ” байгуулж, гар аргаар өсвөр модыг нь огтлох аргаар хортон шавжтай тэмцэх ажлын урьдчилгаанд 5.1 сая

төгрөг өгчээ. Гэтэл “Викингийн ой” ХХК-д хийсэн ажлын гүйцэтгэл, хүлээн авсан акт алга байна.

5.62 Энэ компанийн хортон шавжтай тэмцэх арга нь эрвээхэй болон гацуурын долонч том цох бүхий модыг ялган, түүвэрлэн огтолж авах арга бөгөөд энэ нь БОАЖЯ болон эрх бүхий байгууллагаар баталгаажуулж, хаана ч хэрэглэгдэж байгаагүй шинэ арга юм. Энэ аргаар хэрэгжүүлбэл 1000 гаруй га ойн талбайгаас арчилгааны огтлолоор шинэ залуу өсвөр мод огтлох болж байна. Өөрөөр хэлбэл ойг хамгаалах хөнөөлт шавжаас хамгаалах үндсэн зарчмаасаа хазайх болж байна. Иймд хийсэн ажлын гүйцэтгэлийг шалгаж, дараагийн хэсгийн санхүүжилтийг хийхгүй байх нь зүйтэй гэж үзэж байна.

Бүлэг 6. Боловсон хүчин хүрэлцээгүй байна

БОА, ойн салбар нэгжүүд мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдаагүй байна

6.1 Ойн газрын даргын 2009 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 50 дугаар тушаалаар баталсан дүрмээр Ойн алба 4, сум дундын ойн анги 5 орон тоотой байхаар заажээ. Ойн газраас гаргасан судалгаагаар ой бүхий 12 аймагт 58 хүн ойн асуудал хариуцан ажиллаж байна. Үүнээс 42 нь ойн мэргэжлийн инженер техникч, 16 нь экологич болон бусад мэргэжлийн хүн байна. Орон нутагт мэргэжлийн хүмүүс дутагдалтай учир мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангамж муу байна.

6.2 Мөн дээрх судалгаагаар Өмнөговь Дорноговь, Дундговь, Говь-Алтай, Баянхонгор, Ховд, Сүхбаатар, Говьсүмбэр аймгийн БОАЖГ-т ойн асуудал хариуцсан хүн байхгүйгээс бусад мэргэжлийн хүн хавсран гүйцэтгэж байна.

- Хөвсгөл аймгийн БОАЖГ, ойн алба, сум дундын ой ангид нийт 63 хүн ажиллаж байгаагаас 36 нь мэргэжлийн, 27 нь мэргэжлийн бус болон мэргэжилгүй хүмүүс байна.
- Архангай аймгийн байгаль орчин, ойн салбарт 90 хүн ажиллаж байгаагаас байгаль орчин аялал жуулчлалын мэргэжилтэй 29, бусад мэргэжлийн 38, мэргэжилгүй 23 хүн байна.

БОАЖЯ-нд ойн мэргэжлийн боловсон хүчний хангалт, цаашдын төлөв байдлын талаар судалгаа алга байна

6.3 БСШУЯ-наас авсан судалгаагаар¹⁵ 2008-2009 оны хичээлийн жилд төрийн өмчийн сургууль /Тухайлбал, МУИС, Ховд их сургууль, ХААИС, ШУТИС, Дархан-Уул аймаг дахь УГТСЭШХ, Улаанбаатар дээд сургууль/-д ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн инженер мэргэжлээр нийт 133 оюутан суралцаж байгаа бөгөөд жилд дунджаар 40-50 орчим мэргэжилтэн төгсөж байна.

6.4 Харин ойн мэргэжлийн боловсрол олгож буй хувийн хэвшлийн болон МСҮТ-үүдэд ямар мэргэжлээр, хичнээн суралцагч суралцаж, төгсөж байгаа талаар мэдээлэл, судалгаа алга байна. БОАЖЯ болон Ойн газар салбарын мэргэжилтэнг хэрхэн бэлтгэж байгаа болон мэргэжлийн боловсон хүчний хангалт, цаашдын хандлага, хэрэгцээг тогтоосон судалгаагүй байна.

¹⁵ Эх сурвалж: БСШУЯ-наас авав.

6.5 Хуулийг хэрэгжүүлж ойн санг нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагуудад ямар түвшний хичнээн мэргэжилтэн, түүнийг хэрхэн бэлтгэх талаар судалж, төлөвлөсөн зүйлгүй байна.

6.6 ШУТИС-ын дэргэдэх Ой модны сургалт, судалгааны хүрээлэнгээс ирсэн саналыг үндэслэн БОАЖС, БСШУС-ын хамтарсан тушаалаар байнгын сургалт явуулах мэргэжлийн сургалтын курсыг ажиллуулах төсөл боловсруулалтын шатанд байна.

Бүлэг 7. Ойн нөөц, төлөв байдлыг шинэчлэн тогтоосон байдал

Ойн газраас 2009 оны 5 дугаар сарын 12-ны байдлаар улсын ойн сангийн талаарх мэдээллийг шинэчлэн тогтоосон ч зарим тоон үзүүлэлтийн өөрчлөлт үнэн зөв илэрхийлэгдээгүй байна

7.1 Улсын ойн санд 1974 онд анх удаа нэгдсэн тооллого хийж, ойн сангийн нийт талбай, нөөц, нийт нутаг дэвсгэрийн хэдэн хувийг эзэлж байгааг тогтоож өгсөн. Үүнээс хойш 30 гаруй жил тооллого хийгдээгүй, зөвхөн тодорхой нэгэн аймаг, сумын эзэмшлийн ойн санд ойн зохион байгуулалтын ажлыг нэгдсэн журмаар гүйцэтгэж байна.

7.2 Хуулийн 12.1.8-д¹⁷ заасны дагуу төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн дагуу ойн нөөцийн төлөв байдлыг тодорхойлох ёстой.

7.3 Ойн газраас 2008 онд хийгдсэн ой зохион байгуулалтын ажлын үр дүнг тусган ойн сангийн талаарх мэдээллийг 2009 оны 5 дугаар сарын 12-ны байдлаар гаргасан байна. Улсын ойн сангийн талбайн болон бусад үзүүлэлтийг 1999 оны зарим үзүүлэлттэй зэрэгцүүлэн харуулав.

7.4 Хүснэгтээс үзэхэд 2009 оны байдлаар Монгол Улсын ойн сангийн талбай 18,8 сая га, үүнээс ойгоор бүрхэгдсэн талбай 70.7 хувь буюу 13.3 сая га, ойгоор бүрхэгдээгүй талбай 22.9 хувь буюу 4.3 сая га, ойн бус талбай 6.4 хувь буюу 1.2 сая га талбайг эзэлж байна.

ОЙН НӨӨЦ, ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ¹⁶

		ҮЗҮҮЛЭЛТ	2009 он	1999 он	Өөрчлөлт /+: -/
МОНГОЛ УЛСЫН ОЙН САНГИЙН ТАЛБАЙ /мян.га/	Ойгоор бүрхэгдсэн талбай	Байгалийн ой	12 583,0	12 670,3	(87,3)
		Сөөг торлог	717,8	415,6	302,2
		Таримал ой	0,3	0,1	0,2
		Дүн	13 301,1	13 086,0	215,1
	Ойгоор бүрхэгдээгүй талбай	Тармаг ой	2 939,4	2 900,4	39,0
		Шатсан талбай	824,3	417,8	406,5
		МБ талбай	225,4	193,7	31,7
		Ойжих талбай	257,7	438,8	(181,1)
		Ойж-сан талбай	2,9	0,6	2,3
		ХШӨН талбай	59,5	-	59,5
		Дүн	4 309,2	3 951,3	357,9
	Ойн талбайн дүн		17 610,4	17 037,3	573,1
	Ойн бус талбай	Хад, бэл.цаг/энгэр	1 012,3	1 402,9	(390,6)
		Нуур, гол намаг	101,6	212,0	(110,4)
		МҮГ, Элс	1,4	1,4	-
		Таг, Царам	123,5	186,4	(62,9)
		Түймрийн зурвас	0,1	0,1	-
	Ойн бус талбайн дүн		1 238,9	1 802,8	(563,9)
	БҮХ ТАЛБАЙ		18 849,3	18 840,1	9,3
	ОЙН НӨӨЦ /сая шоометр/		1 395,4	1 504,8	(109,4)

¹⁶ Эх сурвалж: Ойн газар

¹⁷ "Ойн нөөцийн төлөв байдал, чанарыг тодорхойлох, үнэлгээ өгөх, нөөцийн өөрчлөлт, ашиглалт, хамгаалалтын байдлыг хянах;

7.5 Ойн нөөц 1999 оноос 109.4 сая м³-ээр, байгалийн ойн талбай 87.3 мянган га-гаар, ойжих талбай 181.1 мянган га-гаар тус тус багассан байхад, шатсан талбай 406.5 мянган га-гаар, ойн хөнөөлт шавж өвчинд нэрвэгдсэн талбай 59.5 мянган га-гаар нэмэгдсэн байна.


7.6 Ойн сангийн талбайн 67.5 хувь, нөөцийн 75.2 хувийг болц гүйцсэн хөгширсөн *í é үсүеæ ááæí à. Ýí ý í ü ì î ä áýèòäýè áí èí í òçèì ýð, õ°í°ò èò ø ááææä í ýðäýäýò çýðäýð í é ì î ääçé áí èñí í ääçðóóää ø èí ý çàèóó í é ñýðäýí óðääò ýâò óääààø ðàèòàè* байгаатай холбоотой байна. Мөн энэ нь:

- *Ой нөхөн сэргээх /ойжуулалт, БСУТА/ ажлын чанар, гүйцэтгэл хангалтгүй,*
- *Ойн аж ахуйн арга хэмжээ /арчилгаа, цэвэрлэгээний болон түймэр, хөнөөлт шавж өвчнөөс òàì äääèäò àæèè-í èè õýðýäæèò ì ó,*
- *Хууль бус мод бэлтгэлийг бүрэн хяналтад авч зогсоож чадахгүй байгаагийн улмаас ялангуяа ò°á, ñóòðèí ääçðóí í éðí èõí î í éä äóí ä áí èí í áí èò äçéóýæ ýääà í àñí ü áçèäèéí ø èèí ççñò модод их хэмжээгээр хулгайгаар бэлтгэгдэж байгаатай холбоотой байна.*

7.7 Байгалийн ойн нөөцийг насны бүлэг, талбайгаар үзүүлбэл:

Он	Модны төрөл, /насны бүлгээр/								Äçí	
	Çàèóó í é		Äóí ä í àñí ü í é		Áí èò äçéóýæ ýääà		Áí èò äçèõýí í é		Äçí	
	Òæéáæé	Í°°ò	Òæéáæé	Í°°ò	Òæéáæé	Í°°ò	Òæéáæé	Í°°ò	Òæéáæé	Í°°ò
2009	162,8	6 388,1	1 754,1	163 200,0	1 445,1	175 503,0	6 993,4	1 048 745,3	10 355,4	1 393 836,4
1999	145,6	6 790,8	1 722,6	193 144,2	1 661,5	203 118,9	7 098,9	1 101 714,6	10 628,6	1 504 768,5

7.8 Байгалийн ойн талбай болон нөөцийг модны төрлөөр авч үзвэл:



7.9 Сүүлийн 10 жилд байгалийн ойн талбай 274.0 мянган га талбайгаар, ойн нөөц 111.0 сая м³ хэмжээгээр буурсан байна.

7.10 Нийслэлийн ногоон бүсэд 2008 онд хийсэн тооллогын дүнгээр ойгоор бүрхэгдсэн талбай 1998 оныхоос 7472 га талбайгаар багассан ба үүнд доорх хүчин зүйл нөлөөлсөн байна.

- *Ойн түймэрт 1281 га талбай өртсөн,*
- *Хууль бусаар 3115 га талбайгаас мод бэлтгэсэн,*
- *Хортон шавжид 4139 га талбай*
- *Уур амьсгалын өөрчлөлт,*
- *Иргэд, ААНБ-уудын зүй бус үйл ажиллагаа зэрэг болно.*

7.11 Аудитын явцад 2 чиглэлээр иргэдээс авсан санал асуулгыг болон БОАЖЯ-наас 2009 оны 5 дугаар сард орон нутгийн байгаль хамгаалагчдаас авсан

судалгааны ажлын нөхцөл байдлын талаар өгсөн хариултыг аудитад хамрагдсан ойн бүс бүхий аймгийн байгаль хамгаалагчдаар нэгтгэн хавсралтаар үзүүлэв. /Хавсралт 3, 4, 5-ыг үзнэ үү/

